

# "Хүчирхийлэлд өртсөн хүмүүст үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ" сэдэвт сургалтын тайлан

2007 оны 12 дугаар сарын 10-11

## Улаанбаатар хот, 2007 он

Монгол улсын Эрүүл Мэндийн Яамны харьяа Н.Дашийн нэрэмжит  
Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв

<b>Үйл ажиллагааны нэр:</b>	"Хүчирхийлэлд өртсөн хүмүүст үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ" сэдэвт дотоодын сургалт
<b>Зохион байгуулагдсан газар:</b>	Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
<b>Хугацаа:</b>	2007 оны 12 дугаар сарын 10-11
<b>Зохион байгуулагч байгууллага:</b>	ЭМЯ, ГССҮТ, ХЭҮТ, "Монгол өрх" ГБСЗТ, ХЭАО ТББ, ЦА
<b>Төслийн нэр:</b>	Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэхтөсөл /WP/2006/MOG/INJ/2.1/001/
<b>Оролцогч байгууллага:</b>	ГССҮТ, ШШҮТ, НЦЕГ, ХЭҮТ, Нийслэлийн дүүргүүдийн ба 21 аймгуудын гэмтлийн эмч нар
<b>Санхүүжилт:</b>	ДЭМБ

2007 оны 12 дугаар сарын 12 өдөр

**Талархал**

**Энэхүү сургалтанд хүрэлцэн ирсэн нийт оролцогчид болон сургалтыг зохион байгуулахад техник санхүүгийн туслалцаа үзүүлсэн ДЭМБ-д гүн талархал илэрхийлье.**

**Хурлын зохицуулагч нар**

Боловсруулсан:	Д.Мөнхбат	ГССҮТөвийн ЭЭ дэд захирал
	Ш.Нансалмаа	ГССҮТөвийн НЭМ-ийн эмч
Хянасан:	С.Отгонгэрэл	ГССҮТөвийн захирал
	Р.Шагдарсүрэн	ГССҮТөвийн Клиникийн зөвлөх
Хэвлэлд бэлтгэсэн:	Ш.Нансалмаа	ГССҮТөвийн НЭМ-ийн эмч
	Л.Сод-Од	ГССҮТөвийн СЭШХ туслах ажилтан

Энэ илтгэлийг Н.Дашийн нэрэмжит  
Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн дэргэдэх

## СУРГАЛТЫН ТӨВӨӨС

эрхлэн гаргав.

ГАРЧИГ

<b>Нэг. Сургалтын талаар</b> .....	5
1.1 Хурлын зорилго, зорилтууд .....	6
1.2 Нээлтийн үйл ажиллагаа .....	6
<b>Хоёр. Сургалтын явц</b> .....	7
2.1 Илтгэл, мэдээлэл .....	7
<b>Гурав. Сургалтын дүгнэлт, зөвлөмж</b>	
4.1 Сургалтын зөвлөмж .....	53
Хавсралт 1 .....	55
Хавсралт 2 .....	56
Хавсралт 3 .....	58

ДЭМБ-ийн санхүүжилтээр "Хүчирхийлэлд өртсөн хүмүүст үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ" сэдэвт сургалтыг 2007 оны 12 дугаар сарын 12-ны өдөр ГССҮТөвийн хурлын танхимд зохион байгуулав.

### **Нэг. Сургалтын талаар**

Сургалтын даргаар Р.Шагдарсүрэн /ГССҮТөвийн СЭШХ дэд захирал/, орлогч даргаар Р.Энхсайхан /ГССҮТ-ийн ЯТЭ орлогч дарга/, нарийн бичгийн даргаар Л.Сод-Од /ГССҮТ-СЭШХ туслах ажилтан/ нарыг тус тус томилов.

Сургалтанд оролцогч байгууллагууд: ГССҮТөвөөс: С.Отгонгэрэл /ерөнхий захирал/, Д.Мөнхбат /ЭЭОрлогч дарга/, Р.Энхсайхан /ЯТЭОрлогч дарга/, Р.Шагдарсүрэн /СЭШХ дэд захирал/, Ш.Нансалмаа /НЭМ-ийн эмч/, Б.Түмэн-Өлзий /Статистикийн их эмч/, Д.Гантулга /их эмч/, С.Сүхбат /их эмч/, Т.Дэлгэрхүү /их эмч/, Х.Туяа /их эмч/, М.Тэмүүжин /их эмч/, Э.Галбадрах /их эмч/, Б.Батбаяр /их эмч/, А.Амгаланбаатар /их эмч/, Д.Баасанжав /их эмч/, Л.Батхуяг /их эмч/, Т.Бат-Эрдэнэ /их эмч/, Л.Нанжид /их эмч/, Ш.Цэцэгсанаа /их эмч/, Г.Батмөнх /их эмч/, Ц.Цэнд-Очир /их эмч/, Г.Бадамгарав /их эмч/, Р.Баяртулга /их эмч/, Н.Оюунчимэг /их эмч/, И.Гантулга /их эмч/, Б.Янжинлхам /их эмч/, С.Цэрмаа /их эмч/, Т.Төртулга /их эмч/, н. Мөнхсайхан /их эмч/, Д.Оюунжаргал /их эмч/, Д.Даваажаргал /их эмч/, А.Эрдэнэбилэг /их эмч/, Батсүх /их эмч/, Б.Батаа /их эмч/, Баярсайхан.Б /их эмч/, Д.Бархүү /их эмч/, Д.Ариунзаяа /их эмч/, С.Баатаржав /их эмч/, Ч.Мөнхбат /их эмч/, С.Татаар /их эмч/, Г.Ариунаа /их эмч/, Д.Мөнхбаяр /их эмч/,

Б.Цэцэнхүү /бага эмч/, С.Гэрлээ /бага эмч/, Б.Эрдэнэбат /их эмч/, П.Баярсайхан /их эмч/, ХЭҮТ-өөс: Л.Бадамцэцэг /мэргэжилтэн/, "Монгол Өрх" ГБСЗТөвөөс: С.Баасанбат /сэтгэл зүйч/. ЦА-аас: Б.Батзориг /ЦА-ын ахлах багш, доктрант/ "ХЭАО" сангаас: Б.Тунгалагнаран /төслийн мэргэжилтэн/. ШШҮТ-өөс: Н.Мөрөн /ШШҮТ-ийн ШЭХ-ийн менежер/, Н.Долгорсүрэн, С.Ганболд, н. Аюушбаатар, н.Энхбаяр, НЗЕГ-аас: Б.Шаравжамц, Н.Сүхбаатар, Д.Энхтөр, н.Бавуу, н.Наранцолмон, БГД-ийн ЭМН-ээс: Л.Наранбаатар /БГД-ийн гэмтлийн эмч/, БЗД-ийн ЭМН-ээс: Ц.Уртнасан /БЗД-ын гэмтлийн эмч/, СБД-ийн ЭМН-ээс: Ц.Энхтуяа /СБД-ийн гэмтлийн эмч/, ЧД-ийн ЭМН-ээс: С.Алтанзул /ЧД-ын гэмтлийн эмч/, ХУД-ын ЭМН-ээс: Ж.Эрдэнэчимэг /ХУД-ын гэмтлийн эмч/, Налайх дүүргийн ЭМН-ээс: Б.Батжаргал /НД-ийн гэмтлийн эмч/, Багахангай дүүргийн ЭМН-ээс: Л.Гандираа /БХД-ийн гэмтлийн эмч/, Багануур дүүргийн ЭМН-ээс: Т.Цагаандорж /БНД-ын гэмтлийн эмч/, Архангай аймгаас А.Баттулга /НЭ-ийн гэмтлийн

эмч/, Баянхонгор аймгаас Д.Ганзориг /НЭ-ийн гэмтлийн эмч/, Баян-Өлгий аймгаас З.Хурметхан /НЭ-ийн гэмтлийн эмч/, Булган аймгаас: М.Олзмөнх /НЭ-ийн гэмтлийн эмч/, Говь-Алтай аймгаас: О.Мэндсайхан /НЭ-ийн гэмтлийн эмч/, Дархан-Уул аймгаас: Энхбаатар /НЭ-ийн гэмтлийн эмч/, н.Эрдэнэтулга /НЭ-ийн гэмтлийн эмч/, Дорнод аймгаас: Г.Хүрэлбаатар /НЭ-ийн гэмтлийн эмч/, Дорноговь аймгаас: Х.Эрдэнэбулган /НЭ-ийн гэмтлийн эмч/, Дундговь аймгаас: Э.Ариунхүү /НЭ-ийн гэмтлийн эмч/, Завхан аймгаас: Ч.Дэмчигсүрэн, Өвөрхангай аймгаас: Т.Батсайхан, Өмнөговь аймгаас: Ж.Зоригт, Сэлэнгэ аймгаас: Р.Цолмон /НЭ-ийн гэмтлийн эмч/, Сүхбаатар аймгаас: Б.Мангалжав /НЭ-ийн гэмтлийн эмч/, Төв аймгаас: А.Батхүү /НЭ-ийн гэмтлийн эмч/, Ховд аймгаас: Н.Даржаа /НЭ-ийн гэмтлийн эмч/, Хөвсгөл аймгаас: Д.Эрдэнэбаатар /НЭ-ийн гэмтлийн эмч/, Хэнтий аймгаас: Ч.Энхжав /НЭ-ийн гэмтлийн эмч/, Увс аймгаас: Ж.Батсүх /НЭ-ийн гэмтлийн эмч/, ХЭҮТ-өөс Л.Бадамцэцэг /ХЭҮТ-ийн мэргэжилтэн/, "Монгол өрх" ГБСЗТ-өөс С.Баасанбат /Сэтгэл зүйч/, ЦА-аас Б.Батзориг /ЦА-ын ахлах багш/, "ХЭАО" сангаас Б.Тунгалагнаран /сангийн төслийн мэргэжилтэн/. /Хавсралт 2 уулзалтанд оролцогсодын нэрс, албан тушаал/

## **1.1 Сургалтын зорилго, зорилт**

### **1.2 Сургалтын нээлтийн үйл ажиллагаа**

ГССҮТөвийн ерөнхий захирал С.Отгонгэрэл сургалтыг нээж хуралд хүрэлцэн ирсэн нийт оролцогчид болон сургалт явуулж буй багш нарт талархал илэрхийлээд Хүчирхийлэл нь дэлхий дахинд зүй ёсоор анхаарагдах чухал асуудлын нэг бөгөөд хүчирхийлэлд өртсөн хүмүүсд чирэгдэлгүй нэг цэгийн үйлчилгээг тус эмнэлэг дээр байгуулах гэж буй нь цаг үеэ олсон чухал ажил юм. Манай эмнэлэг хамт олны зүгээс зохих хүчийг дайчлан энэ үйл ажиллагаанд оролцох болно. Нэг цэгийн үйлчилгээ нь хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон эмэгтэйчүүдэд хүрсэн үйлчилгээ болно гэдэгт бид бүгд итгэж байна.

Мөн энэхүү сургалтыг зохион байгуулж байгаа ДЭМБ, ЭМЯ болон бусад зохион байгуулж буй байгууллагуудад талархлаа илэрхийлэв.

## **Хоёр. Сургалтын явц**

### **2.1 Илтгэл мэдээлэл**

#### **Сургалтын дарга Р.Шагдарсүрэн хэлсэн үгнээс**

Монгол Улсын Засгийн Газраас Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүч нь гэмтлийн нэг тэргүүлэх шалтгаан болохыг тодорхойлж энэ чиглэлээр

олон төрлийн ажил хийгдэж байна. Хүчирхийлэлтэй тэмцэхэд, урьдчилан сэргийлэхэд, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах, тэднийг сэтгэл санааны хүнд байдлаас гаргах, хүчирхийлэлд өртсөн байдлыг тодорхойлоход үэнэ зөв мэдээлэл өгөх, цаашид хүчирхийлэлд өртөх боломжийг таслан зогсоох зэрэг цогц арга хэмжээг авах бидний энэ сургалтын гол зорилго болох НЦҮ нь улс орон даяар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хугацаанд манай Засгийн газар болон ДЭМБ-ын санхүүжилтийн тусламжаар бүрэн тоногдсон ССТөв байгуулан ажиллуулж хот хөдөөгийн нэлээд олон эмч, мэргэжилтэн хамарсан хурал, зөвлөгөөн, сургалтыг 9 удаа зохиож эдгээр үйл ажиллагаанд ДЭМБ-аас 135000 ам доллар, засгийн газраас 25 сая төгрөг ойролцоогоор 150 сая төгрөгийн санхүүжилт авсан. Гэсэн ч манай эмнэлгийн дүн бүртгэлийн мэдээгээр осол гэмтэлд өртөж эмнэлгийн тусламж авахаар үзүүлж байгаа өвчтөний тоо буурахгүй харин ч 5-8%-аар өсөж байгаа нь бидний санааг зовоох боллоо. Ингээд оролцогч та бүхэн ДЭМБ-ын төлөөгчид, зөвлөхүүдийн зааж байгаа болон бусад мэргэжилтнүүдийн зааж буй сургалтанд идэвхтэй оролцож, өөрсдийн эмнэлгийн дэргэд НЦҮ-г байгуулж түүний эхлэлийг тавих, НЦҮ-ны ач холбогдлыг байгуулж, сурталчилж, зохион байгуулж байгаад талархаж 2 өдрийн сургалтын үйл ажиллагаанд амжилт хүсэв.

## **Гэр бүлийн хүчирхийлэл**

“Монгол Өрх” Сэтгэл Заслын Төв С.Баасанбат

### **“Гэмтлийн эмнэлэг дэх Нэг цэгийн үйлчилгээ”**

Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, мөн чанар, түүний хэлбэрүүд

Гэр бүлийн хүчирхийлэл нь сэтгэл санаа, ураг төрөл, эдийн засгийн харилцан хамаарал бүхий хүмүүс нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр далайлгаж, биеийн болон сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хохирол учруулж байдаг тэнцвэргүй харилцаа юм.

Гэр бүлийн хүчирхийлэл :

\*Хүний амьдралын нэг хэсэг болтлоо байнга үргэлжилдэг эмзэг төвөгтэй асуудал

**ХҮЧИРХИЙЛЛИЙГ ЭКО СИСТЕМИЙН ХУВЬД АВЧ ҮЗЭХЭД**

Слайд 2



Гэр бүлийн хүчирхийллийн харилцааны динамик :

- \* Давтагддаг
- \* Даамжирдаг
- \* Далд явагддаг

ЭРҮҮЛ БУС ХАРИЛЦАА



Слайд 8 - Хүчирхийллийн харилцаа давамгайлсан гэр бүл


## ЭРҮҮЛ ХАРИЛЦАА



Слайд 7 - Зөвшилцөх чадвартай гэр бүл


## ДАВТАМЖ

Слайд 4 - Гэр бүл дэх хүчирхийллийн давтамж




## ДААМЖИРАЛ

Слайд 5 - Гэр бүл дэх хүчирхийллийн даамжирал



## ДАЛД

Слайд 6 - Гэр бүл дэх хүчирхийлэл далд болох нь



Гэр бүл дэх хүчирхийллийн ХОХИРОГЧ эмэгтэй яагаад байсаар байдаг вэ?

ХАЙР СЭТГЭЛ – ИТГЭЛ НАЙДВАР – АЙДАС ТҮГШҮҮР мэдрэмжүүд өдөр тутам ээлжилдэг.

Харилцаандаа дасаж хамааралд ордог.

### Төөрөгдөл

- ◆ Надад хайртайдаа юу эсвэл хайргүйдээ зодож байна уу гэдгийг ойлгохоо больдог.
- ◆ Нэг хүнээс хоёр өөр дүртэй харилцдаг.
- ◆ Энхрийлэл хүчирхийлэл хоёр ээлжилдэг.

Амьдралаа бодитоор харах, дүгнэх чадваргүй болдог.

Хохирогч ямар үед салахаар шийддэг вэ?

- ◆ Засарна, өөрчлөгдөнө гэсэн найдвар нь тасарсан үед
- ◆ Өөрийнх нь амь насанд аюултай болохыг мэдэрсэн үед
- ◆ Гэр бүл, хүүхдийн амьдралд хор хохирол учруулж буйг мэдрэх үед
- ◆ Хэн нэгнээс хэрэгцээт мэдээлэл авсан үед

Хүчирхийлэл үйлдэгчийн үзэл бодол, сэтгэлзүй

- ◆ Хүчирхийллийн аргыг сонгон хэрэглэгчид нь тухайн үеийн зөрчил, зөрөлдөөнийг намжаахын тулд бус **ирээдүйд итгэж болох найдвартай харилцааг** тогтоохын тулд хүч хэрэглэх аргуудыг цогцоор хэрэглэдэг.

Ирээдүйд итгэж болох найдвартай харилцаа нь:

- ◆ Гэр бүлдээ өөрийн гэсэн байр суурь, эрх мэдлийг тогтоох
- ◆ Гэр бүлийн гишүүдээ дуулгавартай байлгахын тулд
- ◆ Өөрийгөө сул дорой биш гэдгээ мэдрэх, мэдрүүлэхийн тулд

Ангилж үзэхэд

- ◆ Хүчирхийллийн зан үйлдлийг зөвхөн гэр бүлийн гишүүдээ гаргадаг. Бусадтай харилцахдаа зан үйлдээ хяналт тавьдаг.
- ◆ Хүчирхийлэл үйлдсэндээ эмзэглэн гэмшдэг, ичдэг. Энэ зан үйлээ өөрчлөхийг хүсдэг.
- ◆ Гэр бүлдээ ч, хамт олондоо ч, хаана ч өөрийнхөө эрх ашгийн төлөө хүч хэрэглэж, түрэмгий зан авир гаргадаг.
- ◆ Аминч

◆ Өөртөө итгэлгүй, сэтгэлийн хямрал, гутралд орсон эрчүүд

Харилцан хүчирхийллийн арга хэрэглэсэн бол яах вэ?

Хэн нь өдөөгч вэ?

Сэдэл зорилгын хувьд ялгаатай байдаг.

Эмэгтэйн сэдэл : Хамгаалалт: /хүчирхийллийг эсэргүүцэх үйлдлүүд/

-хүчирхийллийг болиулах

-архи уухыг нь болиулах

-адилхан хүч үзэх .гм

Эрэгтэйн сэдэл: Дуулгавартай байлгах, эрхшээлдээ оруулах

-Айлгах

-Эсэргүүцээд нэмэргүй гэдгийг мэдрүүлэх

-Мухардуулан туйлдуулах

-Сул дорой, хүчгүй гэдгийг мэдрүүлэх

Үр дүн -

Эмэгтэй – хүчирхийллийг зогсоож чаддаггүй, хамааралд ордог

Эрэгтэй – хүсвэл хүчирхийллийг зогсоож чадна, хүч хэрэглэх аргаа улам

чангатгадаг

Гэр бүл дэх хүчирхийлэлд өртөгсөд болон үйлдэгчдэд хандаж буй нийгэм, эрхзүйн харилцаа



### Хохирогчдын тусламж хайх үйл явц, мухардал

Тэвчих /хүчирхийлэл түр зуурын/ - дахин давтагддаг . /өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийнэ/

- ◆ Ойр дотныхноос тусламж эрнэ. /байдал үргэлжилсээр.../
- ◆ Ламд хандана – тэвчих, засал хийх, салахыг зөвлөх /үргэлжилсээр .../
- ◆ Эмчид хандана. Түүний сэтгэлийн шарх болон өвчлөл эдгэхгүй. Эрт орой хэзээ нэгэн цагт бэртэл гэмтэл авч гэмтлийн эмнэлэгт эмчлүүлээд, буцаад л харина/. /үргэлжилсээр .../
- ◆ Албан ёсны дэмжлэг тусламж хүснэ. Хүчирхийллийн харилцаа улам хурцдан цагдаад хандана. Тэдний аюултай байдал улам нэмэгдэнэ. /үргэлжилсээр .../
- ◆ Нийгмийн халамж үйлчилгээ. Тэдний нийгмийн асуудал нь улам унасаар... тэд болон тэдний гэр бүлтэй ажиллах хууль эрхзүйн болон нийгмийн ажлын үйлчилгээ үгүйлэгддэг. /үргэлжилсээр.../
- ◆ Ямар ч тусламж дэмжлэггүй болохоо мэдэрч, сална эсвэл нийгмийн асуудал нь туйлдан унана. /ямар ч хувийн орон зайгүй болох, амь насаа алдах/

Нийгэм сэтгэлзүйн хэвшмэл хандлага

- ◆ Гэр бүл дэх хүчирхийлэл бол байдаг л зүйл, гэр бүлийн дотоод асуудал
- ◆ Эхнэр өөрөө буруутай
- ◆ Архидалтаас болдог
- ◆ Сэтгэцийн өвчтэй хүмүүс
- ◆ Бэлгийн болон гэр бүл дэх хүчирхийллийг үл тэвчих, эсэргүүцэх сэтгэлзүй бүрдээгүй
- ◆ Нийгмээрээ хэвийн зүйл мэт дассан
- ◆ Гэр бүл дэх хүчирхийллийн аюул, ноцтой байдлыг дутуу үнэлдэг

Жендэр үзэл хандлага

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгэм дэх үнэлэмж болон гэр бүлийн харилцаанд буй “нөхөр нь эхнэрээ дуулгавартай байлгаж, захирах ёстой” гэсэн үзэл хандлага нь хүчирхийлэл үйлдэх сэдэл үүсэхэд нөлөөлж байна.

Нийгмийн халамж үйлчилгээний тогтолцоог интеграчлах

Гэр бүл дэх хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх үйлчилгээ хөгжөөгүй, тус тусын салангид байдлаар явагдаж байгаа гажуудлыг хугацаа алдалгүй засан сайжруулах

- ◆ Хохирогчийн нийгмийн асуудлыг хэвийн болгоход дэмжин туслах үйлчилгээг цогц болгох
- ◆ Гэр бүлийн чиглэлээр ажиллах мэргэжилтэн бэлтгэх
- ◆ Хүчирхийллийн харилцаатай гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтан бэлтгэх
- ◆ Хохирогчийн сэтгэлзүйг нөхөн сэргээх, нийгэм, эрүүл мэнд, сэтгэлзүйн үйлчилгээг хөгжүүлэх
- ◆ Хүчирхийлэл үйлдэж буй эрчүүдийн зан үйлд нөлөөлөх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх

## **Гэмтэл, шархны байдлыг тогтоох систем, ухагдахуун**

ГССҮТ-ийн ЭШСХ дэд захирал, АУ-ны доктор Р.Шагдарсүрэн

### **Гэмтэл, шархны байдлыг тогтоох систем, ухагдахуун**

/triage system and concept/

Цогц үйлчилгээний хамгийн үр дүнтэй алхам бол хохирогчийн бие сэтгэлийн гэмтлийн зэрэг, өвчний явцыг тодорхойлох хамтын протокол юм.

Цогц үйлчилгээний хамрах хүрээ:

Хохирогчийн **тохиолдол**

Гэр ахуйн орчин

Уулзах цэг

Эмнэлэг дэх хүлээн авалт

Нэг цэгийн үйлчилгээ

### **Гэмтэл, шархны байдлыг тогтоох чиг үүрэг**

1. Өвчтөний тухайн үеэс өмнөх байдлын үнэлгээ
2. Яаралтай шинжилгээ, үзлэг хийх
- 3. Яг тухайн нөхцөл байдлыг нэн тэргүүн авч үзэх**
4. Баримтжуулалт
5. Албан ёсны мэдүүлэг /баримт тодорхойлолт/

### **Гэмтэл, шархны байдлыг тогтоох /triage/**

1. Түүх
2. Биомеханизмын гэмтэл
3. Гэмтлийн зэрэг

- Анатомийн
- физиологийн

### **Зэрэглэл тогтоох хэлбэр /tape of triage/**

#### 1. Субъектив:

- Ерөнхий, гадагшаа илэрсэн, хүндрэлүүд
- Эмнэлэгт ирэхээс өмнө хамрагдсан үйлчилгээ
- Анхны хүлээн авсан байдал
- Клиникийн шалгуур үзүүлэлтээс доогуур
- Хаяглах, /tagging/

#### 2. Объектив:

- Мэргэжлийн клиник шалгуур үзүүлэлт
- Үзлэг
- Гэмтлийн зэрэг
- Анатомийн
- Физиологийн

#### 3. Үе шат I.

- Хохирогчийн нөхцөл байдал
- **Хаягласан** - Үзлэгийн карт

#### Үе шат II.

- Хүлээн авах

#### Үе шат III.

- Нэг цэгийн үйлчилгээний төв дэх үйлчилгээ болон бусад
- эмнэлэгийн үзлэг эмчилгээ

### **Гэмтэл, шархны байдалд зэрэглэл тогтоох**

#### 1. Арга барил

- Түүх : тайван ба онцгой байдал
- Холбогдох өвчний түүх
- Клиник нөхцөл байдлын хэд хэдэн шинж тэмдэг
- Гэмтэл авсан он, сар, өдөр, газар
- Клиник баримтжуулалт
- Тодорхой нарийн байх

- Форматлагдсан /батлагдсан маягт/ асуулт хөтлөх

## 2. Үзлэг

- Анхны уулзалт
- Анхан шатны асуулт, ярилцлага
- Дахин үнэлгээ хийх
- Дараагийн түвшний судалгаа
- Гэмтсэн хэсгүүдийг харуулсан зураглал
- Баримтжуулалт /стандарт маягтын дагуу/
- Хувийн, нууцлаг байдлыг хүндэтгэж үзэх
- Эмчийн үзлэг эмчилгээ

### **Өвчтөний нөхцөл байдлын талаарх протокол**

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хүүхдийн хохиролын зэрэглэл, өвчний байдлын талаар олон талаас нь судалж шинжлэх явдал бол цогц сүлжээт үйлчилгээний хамтын ажиллагааны хамгийн чухал хэсэг юм. Энэ протоколд өвчтөний бүх түвшний шинжилгээ, эмчилгээ үйлчилгээг багтаан бичиж баримтжуулсан байна.

- а. Хохирогчийн бие сэтгэл, аюулгүйн нөхцөл байдал
- б. Хохирогчийн гэр бүлийн аюулгүй байдал
- в. Хамгийн эхний уулзалт, хүлээн авсан байдал
- д. Эмнэлэг дэх эмчилгээ үйлчилгээ
- е. Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн байдал

Хохирогчийн нөхцөл байдал ямар ямар шалгууруудаар ирж эмчилгээ үйлчилгээнд хамрагдсан тухай протоколд тусгасан байх ёстой.

P1 - Улаан – Эрсдэл өндөр үе /Critical/

P2 – Шар – Эрсдэл дунд зэрэг байх үе /Semi - critical/

P3 – Ногоон – Эрсдэл бага байх үе /Non critical/

P4 – Цагаан – Ухаангүй эсхүл нас барсан. /Neuro- vegetative or dead/

### **Нэн яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх өвчтөн /хохирогч/**

Эрсдэл өндөр үеийн нөхцөл /Улаан P1/

1. Ухаан алдсан
2. Хүчтэй хөөрөлд орж, амьсгал нь давчидсан
3. Хүчтэй трам /сэтгэцийн цочрол/ авч “паникт” орсон
4. Нүүр нь таталдаж түлэгдсэн, амьсгаа авахад бэрхшээлтэй байгаа

5. Амиа хорлохоор хор уусан өвчтөн, /хэрэглэсэн химийн бодис, мансуурах бодисыг нь тогтоох/
6. Цус алдалт ихтэй, шоконд орж болзошгүй өвчтөнд илрэх шинж тэмдгүүд: зүрхний цохилт түргэсэх эсхүл тасалдаж, царай нь цонхийн цайсан, амьсгал нь давчдах гэх мэт илэрч байвал /цус алдалт 1.5-2л/
7. Цээж, гэдэс хэвлий, аарцаг, толгойн хэсгээрээ хутгалуулсан эсхүл буудуулж гэмтэл авсан
8. Тархиндаа гэмтэл авч хуйхны хэсгээрээ цус алдсан, чих нь дүлийрэх, шуугих, хамраас нь их хэмжээний цус гарах бөөлжих зэрэг шинж тэмдэг илэрч буй
9. Үе мөч нь хугарсан, тасарсан, цус алдсан
10. Цахилгаанд цохиулсан
11. Усанд живсэн
12. Жирэмсэн эмэгтэй

Өвчтөн хүлээн авах эхний ажилтан дээр дурдсан нөхцлүүдийг тодорхой шинж тэмдгүүд /симптомууд/ илэрч байвал гэмтлийн эмнэлэгийн улаан гэрлээр сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасагт хүргэж эмнэлгийн яаралтай тусламж үзүүлнэ.

**Эрсдэл дунд зэрэг байх үе /semi critical/ нөхцөлд /Шар Р2/**

Дараахь шинж тэмдэг илрэх өвчинд хоёр дахь шатны эмчилгээ хийнэ. Үндсэндээ энэ шалгуурт багтах өвчтөн хэд хэдэн гэмтэл авсан байх боловч сэхээн амьдруулах эмчилгээ хийлгэх шаардлагагүй.

1. Урд өмнө нь ухаан алдах, бөөлжих гэх мэт шоконд орж байсан, одоогийн байдлаар ухаантай байгаа, мэдүүлэг өгч ярилцах чадвартай.
2. Жирэмсэн байхдаа гэмтэл авч байсан, хэд хэдэн үр хөндүүлж байсан
3. 15-20% гүн биш түлэгдэлттэй, гэвч сэхээнд орох түвшин биш
4. Өвчтөн явж чадахгүй хэвтрийн байдалтай байж болно.
5. Амьсгал давчдсан эсвэл нилээд сандралд орсон гэвч ноцтой гэмтэл авч шоконд ороогүй
6. Нилээд уйлж хөөрөлд орсон эсхүл сэтгэцийн өөрчлөлтийн зарим симптомууд илэрсэн.
7. Ямар нэгэн гэмтэлтэй, явж чадахгүй байгаа бүх өвчтөн энэ зэрэглэлд багтана.
8. Үе мөч нь гэмтэж, яс хугарсан, хутга мэсний шархтай /1.5л орчимоос бага хэмжээгээр цус алдсан/
9. Амиа хорлох оролдлого хийсэн, гэвч тухайн үед /одоогийн байдал/ тайван тогтуун байдалтай

10. Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн улмаас гэмтэл авсан бага зэрэг цус алдсан.

### **Эрсдэл бага байх үе /Ногоон P3/**

Энэхүү нөхцөл байдалтай байгаа хохирогч тус нэг цэгийн үйлчилгээний төвөөр шууд үйлчлүүлэх боломжтой. Эдгээр хохирогч /өвчтөнүүд тодорхой хэмжээний гэмтэл авсан, гэвч өмнө дурдагдсан ноцтой нөхцөл байдлын түвшинд биш байгаа нь тогтоогдвол нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан холбогдох байгууллага агентлагуудаас зохих тусламж дэмжлэг авах болно.

1. Хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийн улмаас гэмтэж бэртсэн эмэгтэйчүүд, хүүхдүүд бүгд энэ нөхцөлд багтана.
2. Биеийн болон бэлгийн хүчирхийллийн улмаас дээд ба доод үе мөчний зөөлөн эд нь бага зэрэг гэмтсэн.
3. Бэлгийн хүчирхийлэл, дарамт, хүчинд өртсөн бүх хохирогч /өвчтөн сэхээнд орох түвшинд биш/
4. Аваар ослоос бусад бүх тохиолдолд гэмтэл авсан хүүхдүүд энэ үйлчилгээнд хамрагдах болно.

### **Гэмтэл шархны байдлыг тогтоох шалгуур /Triage/**

Категор 1/Улаан P1/

- Тун **өндөр эрсдэлтэй** нөхцөл байдалд байгаа өвчтөн

Категор 2 /Шар P2/

- Нилээд гэмтсэн гэвч урьдчилсан дүгнэлтээр **эрсдэл дунд зэрэг** нөхцөл байдлын зэрэглэлд багтах

Категор 3 /Ногоон P3/

- Бага зэргийн гэмтэлтэй, гэвч эмнэлгийн **эрчимт** эмчилгээ хийлгэх шаардлагагүй

Категор 4 /Цагаан/хар P4/

- Нас барсан

### **Картын зэрэглэл**

Кодны өнгө

Гэмтлийн зэргийг дараах өнгөөр зэрэглэл тогтооно.

- улаан – түвшин 1
- шар – түвшин 2
- ногоон – түвшин 3
- цагаан/хар – түвшин 4

Чухал өгөгдөл

- Гэмтлийн механизм
- **Амьдрах чадварын ерөнхий түвшин**
- Яаралтай хийх эмчилгээ
- Төлөвлөлтийн менежмент

Бусад өгөгдөл

- Зориулалт
- Шилжүүлэх
- Гэмтлийн зэргийн шалгуур үзүүлэлт /өвчний байдал/

### **Гэмтлийн зэрэг тогтоох тогтолцоо**

**Зорилго:** Гэмтлийн зэрэг тогтоох, аюулгүй байдлыг нь хамгаалах

**Тодорхойлолт:**

Хохирогч/өвчтөний гэмтлийн зэрэг, өвчлөлийн байдалд дүгнэлт шинжилгээ хийхийн зэрэгцээ цаашдын аюулгүйн эрсдэл хэвийн зохистой байдалдаа эргэн ороход нь хэрэгцээтэй байгаа нийгмийн үйлчилгээг тодорхойлж олон талт цогц үнэлгээ хийх явдал юм.

### **Гэмтлийн зэрэг тогтоох систем**

Гэмтлийн зэрэг

- Физиологийн түвшинд шинж тэмдгүүд /динамик индикаторууд/
- Анатомийн түвшинд илрэх шинж тэмдгүүд /статик индикаторууд/

Хэрэв бидэнд бололцоо байвал энэ хоёр түвшинд илрэх шинж тэмдгийг нэгтгэж тодорхойлсноор ямар хүчин зүйлээр хэрхэн гэмтсэн, ямар үр дагавар учруулж буйд дүн шинжилгээ хийх боломж гарах юм.

- **Физиологийн өөрчлөлтийн шинж тэмдгийн зэрэглэл**

Тодорхой хэмжигдэхүүнээр физиологийн өөрчлөлт, үр дагаврыг тодорхойлж чадвал эмчилгээний оновчтой жор, дэс дарааллыг тогтоох боломжтой болно.

- **Физиологийн өөрчлөлтийн шалгуур үзүүлэлт**

Ухаан алдалтыг тогтоох тоон хэмжүүр /glasgow coma scola/

- Цусны даралтын systolic тоон хэмжүүр
- Амьсгалын тоон хэмжүүр
- **Ухаан алдалтыг тогтоох хэмжүүр**

Нүдээ нээх:

- Аяндаа нээх 4
- Шаардлагаар нээх 3
- Өвдөлтийн цочролд нээх 2

- Нүдээ нээхгүй 1

Хамгийн сайн үгэн бус хариу үйлдэл:

- Өгсөн командыг дуулгавартай биелүүлэх 5
- Өвдөлтийн цочролд тохирсон хариу өгнө 4
- Хөдөлгөөн байдлаар хариу өгнө 3
- Булчингаа чангалж **тэнийх хөдөлгөөн** 2
- Ямар ч хариу үйлдэл хийхгүй байх 1

Хамгийн сайн үгэн хариу үйлдэл:

- Шууд зөв хариулах 5
- Самуурч будилах 4
- Ойлгомжгүй хариулна 3
- Тодорхойгүй бувтнах /авиа гаргах/ 2
- Ямар ч хариулт байхгүй 1

### **Анатоми өөрчлөлтөнд зэрэглэл тогтоох**

Анатоми өөрчлөлтөнд клиник оношлогоо хийж тоон хэмжүүрээр тодорхойлно.

1. Гэмтлийн зэргийг тоогоор /балл/ илэрхийлэх /AIS/ /abbreviated injury scale/

- Гэмтлийн хэлбэрүүд, гэмтлийг харьцуулах

2. ISS/ Injury Severity Score. Гэмтлийн зэргийг нарийвчилан тогтоох

- Хэд хэдэн гэмтлийн зэргийг судалж тодорхой үзүүлэлтээр тогтоох
- Биеийн тодорхой хэсгүүд дэх гэмтлийг /AIS/-ийн оноогоор зэрэглэл тогтоолгоод хамгийн өндөр баллтай 3 гэмтлийг ялган тогтоох

### **Анатомийн өөрчлөлтөнд зэрэглэл тогтоох**

Гэмтлийн зэргийг /ISS/ тогтоохын өмнө дор дурдагдсан биеийн хэсгүүд дэх гэмтлийн хэлбэр, шинж тэмдгийг тодорхойлно.

1. Ил гэмтэл /арьс, биений бүх хэсгийг нягталж үзнэ/

2. Нүүр

3. Толгой, хүзүү

4. Аюулхай /хэнхэрцэг/

5. Хэвлийн хөндий, аарцагны орчим

6. Ясны үзүүрийн хэсгүүд /аарцагны яс, эгэм, мөр/

### **Анатоми өөрчлөлтийн зэргийг тогтоох хэмжүүр**

- AIS - Гэмтлийг тогтоох категориуд
- AIS.0- Гэмтэлгүй
- AIS.1- Хөнгөн гэмтэл
- AIS.2-Хөнгөвтөр гэмтэл
- AIS.3- Хүндэвтэр гэмтэл /сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ шаардлагагүй/
- AIS.4- Хүнд гэмтэл /сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ авах шаардлагатай/
- AIS.5-Хүнд ноцтой гэмтэл /эмчилгээ авах эсэх нь тодорхойгүй/
- AIS.6-Максимум гэмтэл /эмчилгээ авах найдваргүй/

### **Triage protocol**

- P1- Улаан-Шалгуур үзүүлэлтүүд
- Ухаан алдсан
- Амьсгалахад бэрхшээлтэй
- Нүүрний хэсэг түлэгдсэн
- Амиа хорлох зорилгоор хор хэрэглэсэн /poison, toxic, хорхой шавьж алах бодис/
- Шокын шинж тэмдгүүд, цонхийж цайх, /нүүрний арьс, нүдний зовхины дотор тал, уруулын өнгө/ HR> 100/мин, улам нэмэгдэх PR, цус алдалт 1-1,5л
- Толгойндоо хөнгөвтөр хэд хэдэн гэмтэл авсан
- Хутга мэс, мохоо зүйлд гэмтсэн, бууны сумны шарх
- Зүсэгдэж, тайрагдсан, яс булчин бяцарсан
- Цахилгаанд цохиулсан
- Нойрмог унталтын байдалтай /near drowsing/
- Жирэмсний хүчтэй цочрол /trauma/
- Гэх мэт

### **Гэмтэл, шархны байдлыг тогтоох**

P3 – Шар- Эрсдэл дунд зэрэг /semi - critical/

### **2-р зэрэглэл**

- Цусны эргэлт /хөдөлгөөн тогтвортой/ haemo dynamically stable
- Абортын үеийн бага зэрэг цочролтой /tram/
- Түлэгдэлт байдал, биеийн 15-20% -ийн түлэгдэлтэй
- Унталтын байдалтай /хөл дээрээ явж чадахгүй/
- Дистрессийн улмаас явж чадахгүй байх
- Хүчин, бэлгийн хүчирхийллийн улмаас бага зэрэг / 1,5 л/ цус алдалттай

## **Triage protocol**

### **P3 –Ногоон – Эрсдэл бага /Noncritical/**

- Гэмтэлтэй /хэд хэдэн/
- Нэг цэгийн үйлчилгээний төвд байрлана
- Зохих шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох төрийн байгууллага, агентлаг секторуудтай холбогдох
- Булчин шөрмөсний бага зэрэг гэмтэлтэй
- Хүчирхийлэл үйлдэгчийн учруулсан зэрэглэл хэмжихүйц бус гэмтлүүд
- Хүчин ба бэлгийн хүчирхийллийн бүх тохиолдлууд /гэвч сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний нөхцөл биш/
- Анхаарал болгоомжгүй, аваар ослоос бусад бүх тохиолдлын хүүхдийн гэмтэл бэртэл /хүчирхийлэл/
- **Дүгнэлт**

Хохирогч/өвчтөний бэртэл гэмтлийн шинж тэмдгийг тодорхойлсон эмнэлгийн дүгнэлт, протокол нь тэдэнд ээлтэй, үр нөлөөтэй байх үзэл баримтлалыг зарчим болгохын зэрэгцээ батлагдсан стандартын дагуу хийгдэх ёстой.

### **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээллийг олон нийт, нийгэм хамт олонд тулгуурлан холбогдох байгууллагад уламжлах нь**

ХЭҮТ-ийн Хүүхэд хамгааллын нэгжийн зохицуулагч Л.Бадамцэцэг


### **Хүүхдийн эсрэг ба гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик**

- 2 хүүхдийн 1 нь хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртдөг
- 5 гэр бүл тутмын 1 нь хүчирхийллийн харилцаатай
- 3 эмэгтэй нь 1 нь хүчирхийлэлд өртдөг
- 10 эмэгтэй 1 нь нөхөртөө зодуулдаг

### **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлүүд**

- Биеийн хүчний хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Үл хайхрах

Гэр бүлийн хүчирхийллийн шинж чанарууд



Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаархи мэдээллийг хэн хаана мэдээлэх вэ

- Хүүхдийг эрхийг хамгаалах тухай хуулиар

- Хүүхэд өөрөө
  - Эцэг эх
  - Асран хамгаалагч
  - Харгалзан дэмжигч
  - Иргэн
  - Байгууллага
- } Хуулийн болон бусад байгууллагад

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаархи мэдээллийг хэн хаана мэдээлэх вэ

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар

- Мэдсэн хэн ч мэдээлэх үүрэгтэй.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулиар цагдаагийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх

- Багш нар / цэцэрлэг, ЕБС/
- Эмнэлгийн ажилтан
  - Иргэд
  - Аж ахуйн нэгж

### **Гэр бүлийн ба Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаархи олон нийтийн үзэл хандлага**

- Олон нийт хүмүүжлийн арга, хүчирхийллийн ялгааг төдийлэн ойлгодоггүйгээс хүүхдийг хүчирхийллээс хамгаалах ухамсар дутмаг
- Ойлголт мэдлэг хандлага төлөвшөөгүй
  - Мэдээлэл сурталчилгаа хангалтгүй
  - Урьдчилан сэргийлэх арга зүй хангалтгүй
  - Хүүхэд өөрөө хүчирхийллийг эсэргүүцэн зохих байгууллагад мэдэгдлээ гэхэд хариу ирэх дарамтаас эмээж мэдээлдэггүй

### **Дээрхи байдлыг өөрчлөхийн тулд орон нутагт хэрхэн ажиллах боломжтой вэ**

- Хороон дээр түшиглэсэн **“Хамтарсан баг”**-ийг байгуулж ажиллах. Багийн бүрэлдэхүүнд
  - Хороо / баг/-ы засаг дарга
  - Нийгмийн ажилтан
  - Хэсгийн байцаагч
  - Өрхийн эмч

Гомдол, мэдээлэл гаргах хэлбэр

- ☎ - Утсаар
- 📠 - Факсаар
- 📄 - Бичгээр / өргөдөл /
- ✉ - Шуудангаар
- 👤 - Биеэр / амаар /

Гомдол, мэдээллийг хаана гаргах вэ?

- 🏛 **Цагдаагийн байгууллага - д**
- 🏠 **Сум, багийн засаг дарга – д**
- 🏢 **Холбогдох бусад байгууллага, албан тушаалтан – д**

Гомдол, мэдээллийн дагуу авах арга хэмжээ

- 🏛 Цагдаагийн байгууллага

### **Хохирогчид чиглэсэн**

- Эдлэх эрх болон арга хэмжээний талаар тайлбарлаж өгөх
- Эмнэлэг, хамгаалах байранд хүргэх
- Төрөл, садны хүний түр хамгаалалтанд өгөх
- Холбогдох, тусламж үйлчилгээнд хамруулах талаар **Нийгмийн ажилтанд** мэдэгдэх

### **Хүчирхийлэл үйлдэгчид**

- Захиргааны болон эрүүгийн шийтгэл ногдуулж болох талаар сануулах
- Захиргааны журмаар албадан саатуулах
- Эрүүлжүүлэх байранд хүргэх
- Эрх хязгаарлуулах арга хэмжээ авахуулах хүсэлтийг **Шүүхэд** гаргах

### **Хохирогчид үзүүлэх үйлчилгээ**

- ♥ Хэрэгцээт мэдээллээр хангах
- ♥ Эрхзүйн болон сэтгэлзүйн зөвлөгөө, дэмжлэг туслалцаа үзүүлэх
- ♥ Нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээ

### **Шүүх**

- Хохирогчийн гомдол
- Цагдаагийн ажилтаны хүсэлт
- Өмгөөлөгчийн хүсэлт
- Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт

### **Хохирогчийг хамгаалах арга**

#### **Хамгаалах байранд хүргэх**

- Эцэг, эх, төрөл, садны хүний түр хамгаалалтанд өгөх
  - Хүүхэд асран хүмүүжүүлэх, эсхүл нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх
  - Хохирогчийг хэрэгцээт үйлчилгээ, дэмжлэгтэй холбох
  - Нууцыг хадгалах
  - Хуулийн дагуу холбогдох журмаар асуудлыг шийдвэрлүүлэх, нэхэмжлэл гаргахад дэмжлэг үзүүлэх

#### **Хамтарсан багийн зорилго**

- Хорооны нутаг дэвсгэр дээр гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах
- Хүчирхийллийн харилцаатай гэр бүлтэй ажиллах арга зүйг тодорхойлох

- Хүчирхийллийн харилцаатай гэр бүл дэх хүүхдийг хамгаалах, нийгэмшүүлэхэд нөлөөлөх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

#### **Хамтарсан багийн үйл ажиллагааны чиглэл**

- Судалгаа
- Хүчирхийллийн кейс дээр ажиллах
- Сургалт / хүүхэд, эцэг эх, иргэд/
- Сурталчилгаа
- Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах


#### **Хамтран ажиллахын давуу тал**

- Тухайн асуудлыг өөр өөрийн мэргэжлийн нүдээр олон талаас нь харж, зөв оновчтой шийдвэр гаргадаг
- Мэдээллийг маш хурдан хугацаанд авдаг
- Иргэдэд шуурхай үйлчилдэг
- Ажлын ачаалал тэнцүү хуваарьлагдаж, үр дүн сайн


#### **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээллийг шийдвэрлэх нь**

- **Цагдаагийн байгууллага**
  - Мэдээллийг авсан даруйд шууд таслан зогсоож, хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй
- **Эмнэлэг**
  - Эрүүл мэндийн талаас тусламж үзүүлэх
  - үзлэг шинжилгээг нотлох баримтын чанартай хийх
  - Сэтгэл зүйн зөвлөгөө
- **Нийгмийн хамгаалал, халамжийн байгууллага**
  - Нэн даруй аюултай орчноос тусгаарлах
  - Хамгаалах
  - Хэвийн байдалд эргэн ороход нь нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх


**Хуулийн байгууллагад мэдээлэх үйл явц**



**Эмнэлгийн байгууллага мэдээлэх үйл явц**



## Нийгмийн халамж хамгааллын байгууллага мэдээлэх үйл явц



## Гэмтлийн дараах неоробиологийн өөрчлөлт

“Монгол Өрх” Сэтгэл Заслын Төв С.Баасанбат

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл ба тархины хөгжил хүүхдийн тархины хөгжилд нөлөөлөх нь

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрэх хэлбэр

- Биеийн
- Бэлгийн
- Сэтгэлзүйн
- Үл хайхрах
- Гэр бүлийн

Хүчирхийлэл гэмтэл

- Хүчирхийллийн аль ч элемент хүүхдэд гэмтэл өгдөг.
- Тэд бас хүчирхийллийг сурдаг.
- Тэд бас сурсан шигээ өөрчлөгдөж чадна.

Асуудлын гол гогцоо

- Хүчирхийлэл нь хүүхдийн хөгжил, төлөвшил, эрүүл мэндэд нөлөөлдөг.

- Энэ удаа хүүхдийн тархины хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Хэрхэн нөхөн сэргээх вэ?

#### Тархины хөгжил

- Сүүлийн 10 жил бие, сэтгэлийн харилцан /салангид биш/ шүтэлцээг судлах болсон психосоматик
- Хүний хөгжил, неоробиологи, анагаах ухааныг хамтад нь авч үзэх хандлага бий болсон.
- Тархи нь тус бүр тодорхой үүрэг хариуцлага хүлээдэг, бас багаар ажилладаг хөндлөн гулд байрласан эд эрхтнээс бүрдэнэ.
- Мэдрэлийн эсүүд нь маш ойрхон гавлын ясан дотор оршдог.
- Систем нь бүх эд эрхтэн рүү тархсан байна.

Мэдрэлийн системийг – Төвийн мэдрэлийн  
- Захын мэдрэлийн

#### Төв мэдрэлийн систем

1. Өнчин тархи /cerebellum/ тэнцвэр, булчингийн үйл ажиллагааг хянаана.
2. Уртавтар тархи: /medulla oblongata/ дунд тархийг нугастай холбодог гүүрний /pons/ үүрэг гүйцэтгэнэ.

Амьсгал, хоол боловсруулах эрхтэний автомат үйл ажиллагааг зохицуулдаг олон төвтэй.

- Ү Рефлекс хянаана.
- Ү Биеийн дотоод хэсгийг хянаана.
- Ү Өнчин тархиар дамжуулан хөдөлгөөн хянах, дотоод хэргийн дохиоллуудыг хянах, таламусаар дамжуулан сэтгэл хөдлөл, нойр хянах.

#### Төв мэдрэлийн систем

- Таламус: Өвдөх, хүрэлцэх, дуу чимээг ялгах, зэрэг дотоод ухамсар.
- Гипоталамус: Бэлгийн сэрэл, өвдөх, таалах, таалагдах, өлсөх, цангах, мэдрэмжүүд, цусны даралт, биеийн дулаан, дотоод эрхтэн хянаана.

**Corpus callosum:** Баруун зүүн тархийг холбодог мэдрэлийн багц.

- Дамжуулагч
- Мэдрэлийн ширхэгүүд уртавтар тархинд чигээ өөрчилдөг тул зүүн тархийг баруун тал, баруун тархийг зүүн тал нь удирдана.

Зүүн тархи хийсвэрлэж бодох /тоо/

Баруун тархи дүрслэн бодох /орон зайн баримжаалал/

Зүүн тархи загас гэдгийг уншаад баруун тархины тусламжгүйгээр ойлгохгүй, нүдэндээ төсөөлж чадахгүй.

- Тархины гаднах бүрхүүл саарал өнгийн олон үрчлээстэй, бор бодис /cortex/
- Доод талд нь цайвар өнгөтэй эсүүдийн сэртэнгүүд цагаан бодис /aksonlar/
- 6 давхар
- мэдрэхүйн системээр ирсэн дохиололд анализ хийнэ.
- Сэтгэн бодох
- Санах
- Сурах
- Өөрөө мэдэрч хийсэн булчингийн хөдөлгөөн хянадаг.
- Их тархи нь 85% эзэлнэ.

Тархины хөгжил

- Анх төрөхөд 400гр
- 1 нас 800гр
- 4 нас 1200гр
- 20 нас удааширч 1379-1434гр
- 20-75 нас –нас бүрд 1 гр-аар багасна.

20 наснаас хойш өдөр болгон 50,000 орчим эс маань үхэж дахин сэргэдэггүй.

ТМС-гэмтвэл буцаж сэргэдэггүй.

ЗМЭ-холбоос сэртэнгүүд дахин сэргээж болдог.

- Нугас 31 хос мэдрэл нь сээр нурууны ясны хажуу нүхнээс гардаг.
- Гавлын ясан доторх тархины хэсгээс 12 хос мэдрэл гарна.
- Автомат систем удирдана.

Дотоод шүүрлийн үйл ажиллагааг удирдана.

- Симпатик: Стресс, шоконд хариу үйлдэл үзүүлдэг, цусны даралт, цусны чихрийн хэмнэл, их хөлрөх, хүүхэн хараа тохирох, багасах, цусны урсгал хурдсах үйлдлүүд.
- Парасимпатик: Дотор эрхтэнүүдийн хэвийн үйл ажиллагаа

30 сая орчим нейрон эс бол мэдрэлийн системийн салбар болгонд байдаг үндсэн эс юм.

Аксон – их бие

Дендрит – урт сэртэнгүүд

Хүнд мөн өөрөө өөртөө эзэн болох, өөрчлөх шантрашгүй чадвар.

- Хүний мөс чанар, шүтлэг: Зөвхөн хүний чанар

- Дотоод ухамсарт бичигдсэн муу үйл нь автомат мэдрэлийн системээр таламус, гипоталамуст очин сэтгэлийн тэнцвэр алдагдсанаас өвдөнө.
- Эхэн үед ямар нэгэн эд эрхтэн өвдөхгүй ч сэтгэлийн өвчин даамжирвал бие, эд эрхтэн өвдөнө.
- Эсргээр сэтгэл эерэг өөдрөг байвал өвчин эдгэж ч болно.

#### Баруун тархины хөгжил

- Үгэн бус биеийн хэлэмжийг илэрхийлнэ.
- Сэтгэл хөдлөлийг хүлээн авна.
- Дуу хоолой, үйл хөдлөлд анализ хийж ойлгоно.
- Автомат мэдрэлийн систем, бие байдлыг хянана.

#### Зүүн тархи

- Шугаман онол /тоо/ логик, хэл сэтгэхүйн үйл явц
- Юмс үзэгдлийн шалтгаан үр дагавар
- Зөв ба буруу
- Бодит үнэн ба худал
- Субъектив сэтгэл хөдлөлийг RH-тэй холбоно.

#### PTDO-ийн гэмтлийн дараахь сэтгэцийн өөрчлөлт /стресс/

- Cortex-ын үйл ажиллагааг алдагдуулна.
- Тал бөмбөлөг ба уртавтар тархины хоорондын холбоосыг сулруулдаг.
- Дасан зохицол, тогтвортой байдлын чадварыг алдагдуулна.
- Сэтгэн бодох, үг ярианы систем дарааллыг алдагдуулна.

Сэтгэц: Танин мэдэхүй-сэтгэл хөдлөл-нервийн системийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулна.

- Трам үйл ажиллагаа нь дотооддоо өөрөө өөрийгөө дарамтална.
- Одоо цагаас-одоо руу-орших байдал нь салан тусгаарлагдана.

#### Трамын тодорхойлолт

- Гэмтэл /биеийн/ авсанаас хойш тодорхой хугацааны дараа илэрнэ. /James 1989/
- Хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтөнд саад учруулна.
- Урт удаан хугацаагаар үргэлжилнэ.

#### Хэвийн трам

- Хэвийн тохиолдол
- Богино хугацаанд үргэлжилнэ
- Байнгын өдөөгч цочроогч байхгүй /байгалийн гамшиг, аварь осол/

- Үе үе өөрийн хяналтаа алдаад байхгүй.

#### Complex trauma

- Олон тохиолдол
- Урт хугацаанд үргэлжилнэ
- Өдөөгч /ичгүүр
- Бусдаас тусгаарлагдана
- Зонхилсон айдас
- Биед нь байнгын стресс-alarm

#### Трамын нөлөө

- Сөрөг зан үйлийн эмгэг
- Хөгжлийн саатал /хүүхдийн хөгжлийн үе шат/
- Айдас

#### Ой санамж ба трам

#### Дахин давтагдах

- Хяналтаа алдах
- Болсон үйл явдлыг санахгүй байх
- Паникт орох

#### Болсон явдлыг ойлгох алдаа

- Яагаад-хэрхэн
- Өөрийн мэдрэмжээ мэдрэхгүй байх
- Өөрийнхөө тухай ярихад бэрхшээлтэй
- Мэдрэмжээ нэрлэж чадахгүй
- Мэдрэмжээ илэрхийлж чадахгүй
- Мэдрэмжээ хянаж зохицуулах чадвар сул

#### Хроник трам сэтгэл хөдлөлд нөлөөлөх нь

Эцэг эх, асран хамгаалагчтайгаа ойлголцоход бэрхшээл учирна.

- Итгэх
- Ойлголцох
- Хяналтаа алдах
- Уур уцаартай, хэдэр болох
- Ичгүүр, гутамшиг

### Засал

- Бие дэх /alarm/ стрессийг бууруулах /булчин суллах/
- Бодит ба бодит бус байдлын ялгаа /газардуулах/
- Мэдрэмжээ нэрлэж сурах
- Бусадтай нөхөрлөх чадвар

### Засал

- Би дараагийн долоо хоногт ямар нэгэн юм хийнэ...
- Би бол сайн хүүхэд
- Би үүнийг мэдмээр байна.
- Би үүнийг хийж чадна.
- Би үүнийг сурч чадна.
- Би үүнийг сонсох дуртай
- Би үүнийг хэлж чадна.
- Би тоглох дуртай.
- Би өөртөө хайртай.
- Тэд надад хайртай.

## **Гэмтлийн эмнэлэг дэх нэг цэгийн үйлчилгээ /НЦҮ/**

“Монгол Өрх” Сэтгэл Заслын Төв С.Баасанбат

**НЦҮ гэдэг нь:** Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд цогц дэмжлэг туслалцаа үзүүлэх байгууллага, мэргэжилтнүүдийн багийн үйлчилгээг уялдуулан зохицуулах явдал юм.

НҮЦ-ний үзэл баримтлал

Өвчтөнд ээлтэй тогтолцоо

- ▣ Өвчтөн төвтэй:

Өвчтөн, түүний гэр бүлийн нийгмийн өвөрмөц хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээ

- ▣ Анхаарал халамжтай:

Өвчтөнийг хүндэтгэж, элэгсэг энгийн харилцана.

- ▣ Мэргэжлийн түвшинд:

Өвчтөний хохирлын /гэмтлийн/ нөхцөл байдлыг туйлын /максимум/ үнэн зөв эмнэлгийн үзлэг, мэргэшсэн ажилтнуудын оролцоо.

#### Үйлчилгээний чиглэл

- ▣ Хүчирхийлэлд өртсөн өвчтөний аюулгүй байдлыг хангасан, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх тав тухтай оролцоо.
- ▣ Биеийн болон сэтгэл заслын үйлчилгээ
- ▣ Бие сэтгэцийн гэмтэл /трам/ авсан хохирогчийг эмчлэх, холбогдох байгууллагуудын оролцоог зохицуулах.
- ▣ Эмнэлгийн дүгнэлт гаргах.

#### Шаардлагатай үйлчилгээнүүд

##### Эмнэлгийн яаралтай тусламж

- ▣ Бэртэл гэмтлийг эмчлэх багийн менежмент
- ▣ Өвчтөний бие сэтгэлийн байдлын талаар эмнэлгийн дүгнэлт гаргах
- ▣ Сэтгэлзүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх.

##### Цагдаагийн оролцоо

- ▣ Өвчтөнөөс мэдүүлэг авах
- ▣ Өвчтөний аюулгүй байдлыг хамгаалах
- ▣ Мөрдөн байцаагчид мэдүүлэх
- ▣ Хэрэг бүртгэх

##### Нийгмийн ажлын үйлчилгээ

- ▣ Түр хугацаагаар хамгаалан байрлуулах
- ▣ Хохирогчийн /өвчтөн/ эрсдэл, хэрэгцээг тодорхойлох
- ▣ Сүлжээт үйлчилгээг төлөвлөх, зохицуулах

##### Төрийн бус байгууллага

- ▣ Шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө өгөх /para counselling/
- ▣ Түр хугацаагаар хамгаалан байрлуулах
- ▣ Нийгмийн үйлчилгээ үзүүлэх /хохирогчийг чадавхижуулах/

##### Хэн үйлчлүүлэх вэ?

- ▣ Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн өвчтөн
- ▣ Хүчингийн хохирогч /өвчтөн/
- ▣ Бэлгийн ёс бус үйлдлийн хохирогч эмэгтэйчүүд, хүүхдүүд

##### Төрийн байгууллагын оролцоо

- ▣ Эрүүл Мэндийн Яам, эмнэлгүүд
- ▣ Цагдаа

- ▣ Нийгмийн Хөдөлмөр Хамгааллын Яам, хэрэгжүүлэгч агентлагууд /хамгаалах байр/
- ▣ Хүүхдийн байгууллагууд
- ▣ Хууль шүүх
- ▣ Боловсрол


Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр

Эрүүлийг хамгаалах үйлчилгээ дараахь түвшинд тодорхой чиг үүрэгтэйгээр оролцоно.

Үр дүнтэй, өргөн далайцтай хэрэгжих нөөц.


- A. УСХ 1 дэх түвшин: Олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх нийгмийн эрүүл мэндийн хэлтэс
- B. УСХ 2 дахь түвшин: Сэргээн засах клиникийн эмчилгээ, эмнэлгийн үйлчилгээ
- C. УСХ 3 дахь түвшин: Нөхөн сэргээх, хямралаас гарч хэвийн байдалд нь оруулах нийгэмшүүлэх үйлчилгээ.

НЦҮ-ний бүдүүвч



## НЦҮ-С

### Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ



Нэг цэгийн үйлчилгээний дэд бүтэц

▣ Бүрэлдэхүүн хэсэг:

1. Зөвлөгөө мэдээлэл өгөх, бүртгэл

- ▣ Өвчтөний түүх
- ▣ Цагдаад мэдээлэх
- ▣ Зөвлөгөө мэдээлэх

2. Эмнэлгийн үзлэгийн хэсэг

- ▣ Загвар маягтуудын бүрдэл хэсэг
- ▣ Баримтжуулах үйл явц /лацдах/
- ▣ Эмчилгээ заслын үйл явц
- ▣ Эмнэлгийн дүгнэлт

3. Түр хугацаагаар байрлуулах

- ▣ 24 цагаар байрлуулах
- ▣ Үргэлжлүүлэн түр хугацаагаар байрлуулах

4. Анхаарал халамж тавих

- ▣ Угаалгын өрөө /усанд орох/
- ▣ Хувцас солих шүүгээ
- ▣ Ор хэрэгсэл

## НЦҮ-ний стандарт

### Зохих нөхцлийг бүрдүүлэх

1. Яаралтай тусламж үзүүлэх үйлчилгээ цаг
2. Нууцлаг байх: Олны хөлд биш, анхаарал татахааргүй байршил
3. Аюулгүй нууцлагдсан байх
4. Зориулалтын бус зорилгоор ашиглахгүй байх
5. Тохь тухтай байх

### Зохих хэрэглээ, үйлчилгээ

1. Болсон үйл явдлыг бичиж баримтжуулах /файлны шүүгээ/
2. Зөвлөгөө, мэдээлэл өгөх
3. Үзлэг хийх ор
4. Шүүх эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийх тоног төхөөрөмж
5. Бичлэг хийх хэрэгсэл тоног төхөөрөмж
6. Нэвт харах толин хана
7. Хүлээлгийн өрөө
8. Хүүхдийн тоглоомын булан

НЦҮ-ний 2 дахь түвшний үйлчилгээний загвар



НЦҮ-ний 3 дахь түвшний үйлчилгээний загвар



### Нэг цэгийн шүүх эмнэлгийн оролцоо

ШШҮТ-ийн ШЭХ-ийн менежер, Гистологи-лабораторийн эрхлэгч,  
АУ-ны магистер Н.Мөрөн

#### Нэг цэгийн шүүх эмнэлгийн оролцоо

Эмнэлэгийн яаралтай тусламж үзүүлэх үйлчилгээний хүрээнд эрүүлийг хамгаалах тогтолцооны өнөөгийн нөхцөлд бэртэл гэмтэл авсан хохирогчдын зонхилох хэсэг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд байдаг. Эдгээр хохирогчид нь тухайн цаг үедээ эмнэлэгийн тусламж авах, эмчилгээ үйлчилгээнд хамрагдах, тэдний өвөрмөц хэрэгцээнд нийцэх сэтгэл ханамжтай дэмжлэг авах нь ээлтэй бус байдаг. Иймд тэдэнд хэрэгцээтэй байдаг бусад мэргэжлийн багийн цогц үйлчилгээ дутагдаж байдаг хүчирхийлэлд өртсөн хохирогчдийн өвөрмөц хэрэгцээ нь эмнэлэгт төвлөрсөн, нарийн мэргэжлийн эмэгтэйчүүд, хүүхэд, шүүх эмнэлэг, сэтгэцийн эмч болон нийгмийн эрүүл мэндийн ажилтануудын оролцоо шаардагдаж байна.

Нэг цэгийн үйлчилгээ нь эмнэлэгт төвлөрч, холбогдох төрийн ба төрийн бус байгууллагын оролцоог зангидан зохицуулах менежментээр зохион байгуулагдсан байх ёстой. Үүний нэг хэсэг нь шүүх эмнэлэгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах явдал юм.

Энэ үйлчилгээнд хамрагдах шүүх эмнэлэгийн нэг объект болох амьд хүнд буюу хохирогчдын биед үзлэг шинжилгээ хийж шүүх эмнэлэгийн магадлагаа явуулж дүгнэлт гаргаж байгаа өнөөгийн шүүх эмнэлэгийн үйлчилгээний талаар товч ойлголт өгье. Шүүх эмнэлэгийн магадлагааг явуулахад хохирогч дараах зүйлийг бүрдүүлж шүүх эмнэлэгт өөрийн биеэр үзүүлэх ёстой.

- Хуулийн байгууллагын тогтоол /хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх/-той ирнэ.
- Өөрийгөө гэрчлэх /иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх, гадаад паспорт/ бичиг баримттай ирнэ.
- Үзүүлэгч нь цаг хугацааны хувьд хэдийд ч ирж үзүүлж болох боловч шархны ариун боолт хийгдсэн тохиолдолд дараагийн боолтыг хийлгэхийн өмнө үзүүлэх нь зүйтэй.
- Хүчингийн үзлэгийн үед хугацаа алдалгүй 24-48 цагийн дотор үзүүлэх шаардлагатай.

Шүүх эмнэлэгийн шинжээч эмч хохирогчийн биед үзлэг хийж дараах зүйлийг анхааран тогтоосон байна.

- Биед байгаа гэмтлийн /цус хуралт, шалбаралт, шархны/ шинж байдал, байрлал, хэлбэр, хэмжээ, өнгө, зах ирмэгийн тархалт, эдгэрэлтийн явц
- Уг гэмтэл нь ямар хүчин зүйлийн үйлчлэлээр үүссэн
- Хэдийд үүссэн хугацааг тогтоох боломжийн хирээр тогтоох
- Уг гэмтэл нь гэмтлийн ямар зэрэгт хамаарах
- Цаашид энгийн хөдөлмөрийн чадварт ямар хувь хэмжээгээр нөлөөлөх

Хэрэв хохирогч бэлгийн хүчирхийлэлд автсан нөхцөлд дараах зүйлийг анхааран тогтоох.

- Хохирогчид бэлгийн үзлэг хийх тухай, эмчийн үзлэгийн тухай, бодит байдлыг аль болох үнэмшилтэй ойлгуулах
- Болсон хэргийн байдлын явцыг тодорхой яриулах
- Гадна бэлэг эрхтэний байдал
- Охин хальсны бүрэн бүтэн байдлыг үзэж /шинэ ба хуучин гэмтэл, төрлөхийн сэтэрхийтэй эсэхийг/ тогтоох.
- Охин хальсны зах ирмэг зузаан, нимгэн, иржгэр, долгионтсон г.м.
- Охин хальсны нүхний хэлбэр, хэмжээ, нүхний диаметр.
- Хальсны өндөр, суурь хэсгийн байдал.
- Охин хальсанд урагдалт, ялзралт, цус хуралт, сорвижилт үүссэн бол хэлбэр хэмжээ, өнгө, байрлал/ цагийн зүүний байрлалаар зааж бичих.

- Үтрээнээс гарсан ялгадасын байдал, өнгө, үнэртэй эсэхэд анхаарах.
- Үтрээнээс болгоомжтойгоор зориулалтын савх, толь тавьж бактериологи, биологийн лабораторийн шинжилгээнд сорьц авах.
- Мөн хошногны амсрын байдлыг тогтоох.
- Биед гэмтэл байгаа эсэх, хумсны завсар, бие, бэлэг эрхтний орчинд үзлэг хийж сул үс болон бусад үлдэцийг тогтоох, авах.
- Хувцасанд ямар нэг бохирдлын зүйл үлдсэн эсэхэд анхаарч илэрвэл лабораторийн шинжилгээнд зохих журмын дагуу материал авах.
- Шинжилгээнд авсан материалуудыг дагвар бичгийн хамт зохих лабораторуудад хүргэж өгнө.

Малайзын нэг цэгийн үйлчилгээгээр өргөн хүрээнд үзлэг шинжилгээг хийж үйлчилгээг үзүүлдэг туршлага байгаагийн заримаас дурьдвал:

- Гэмтлийн талаар мэдээ цуглуулж баримтжуулах
- Хүүхдийн бие эрүүл мэндэд үзлэг хийж хүчирхийлүүлсэн эсэхийг тогтоох
- Хүүхэд болон түүний гэр бүлд боловсрол, мэдлэг олгох.
- Хүүхдийг эмчилгээнд оруулахад туслах.

*Үзлэгийг яаралтай хийх тохиолдол.*

- Хүчирхийллээс хойш 72 цагийн дотор /эр үрийн шингэн г.м нотлох баримт олж авах/
- Бэлэг эрхтэн ба хошногноос цус алдсан үед
- БЗХӨ-ний шинж илэрч байвал.

*Сайн дурын үзлэг хийлгэж болно.*

- Хохирогч бүр 72 цагийн дотор үзлэг хийлгэх албагүй дараах тохиолдолд хүссэн үедээ үзлэг хийлгэж болно.
- Хүчирхийллээс хойш 72 цагаас дээш хугацаа өнгөрсөн
- БЗХӨ-ний эмчилгээ хийлгэсний дараа
- Зан төлвийн өөрчлөлттэй болсон

Бэлгийн замын үзлэг шинжилгээ хийхэд зориулагдсан тусгай оношлуур, аппарат төхөөрөмжөөр тоноглогдсон цүнх байдаг байна

## **Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн Монгол дахь байдал**

ХЭҮТ-ийн Хүүхэд хамгааллын нэгжийн зохицуулагч Л.Бадамцэцэг

### **Тойм үнэлгээний зорилго, арга зүй:**

- Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл/хүүхдийн эсрэг хүчирхийллийн Монгол дахь байдлын тухай суурь мэдээллийг бүрдүүлэх, өнөөгийн нөхцөл байдлыг тоймлон харуулахад чиглэгдсэн.
- Энэ хүрээнд хүчирхийллийн дээрх төрлүүдийн:
  - Цар хүрээ, тархац
  - Шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлс
  - Сүүлийн үеийн динамик, хандлага хүчирхийллийн түвшинг бууруулах чиглэлээр төр, ТББ-ууд, НҮБ болон олон улсын байгууллагуудын /цаашид ОУБ-ын гэх/ хийсэн алхмууд, тэдгээрийн ололт амжилт, үр дүн, бэрхшээл, сургамжийг гаргаж ирлээ.

### **Судалсан асуудал**

- Гэр бүлийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл, хүчин
- Ажлын байран дах хүчирхийлэл
- Хил дамжуулан худалдаалах гэмт хэрэг
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл

### **Цар хүрээ, үр дагавар:**

- Хүчирхийллийн аль ч хэлбэр нь Монголын нийгэмд түгээмэл үйлдэгдэж байгаа хэдий ч мэдээлэгдэх, бүртгэгдэх нь бага, нуугдмал далд оршиж байна.
- Эдгээр хүчирхийллийг харилцааны энгийн асуудал, жирийн байж болох зүйл гэж ойлгох, хүлээн зөвшөөрөх нийгмийн хандлага нь далд байлгах хүчин зүйл болж байна.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, насанд хүрэгчдэд ч ялгаагүй хүчирхийллийг мэдээлэх аюулгүй, итгэлтэй арга зам байхгүй байгаа нь нуугдмал байхад нөлөөлж байгаа бас нэг хүчин зүйл юм.
- Мөн хүчирхийллийн дээрх төрлүүд нь ихэвчлэн гэрчгүй үйлдэгддэг, хохирогч айдастай байдаг, мэдээлвэл ичгүүрт байдалд орно гэж үздэг нь далд байх нэг хүчин зүйл болж байна.
- Энэ нь цагдаа, орон нутгийн засаг захиргаанд олон нийт итгэдэггүйтэй холбоотой байна. Учир нь эдгээр байгууллагууд авсан мэдээллийнхээ нууцыг хадгалах,

бүрэн бүтнээр нь тогтмол, үнэн зөв бүртгэх, мэдээллийн дагуу шуурхай арга хэмжээ авах явдал дутагдалтай.

- Хүчирхийллийн тохиолдлыг бүртгэх стандартчлагдсан тогтолцоо цагдаа, шүүх, эмнэлгүүдэд байхгүй, байгаа бүртгэл мэдээлэл нь олон нийтээс хаалттай байдаг.

#### **Цар хүрээ, үр дагавар:**

- Хүчирхийллийн дээрх төрлүүдийн үр дагаврыг Монголын нийгэмд одоогоор гүйцэд танин мэдээгүй, энэ талаар нарийвчлан судалсан судалгаа хангалтгүй. Ялангуяа хүчирхийлэл нь хувь хүний болон нийгмийн эрүүл мэндэд аюул учруулж байгаа ч эрүүл мэндийн асуудал болох талаас нь анхаарал хандуулах явдал сул.
- Эрүүл мэндийн томоохон эрсдэл болох жендерээс үүдэлтэй хүчирхийллийг Монголын МХЗ-ын аль нэгэн зорилтонд тусгайлан хамруулаагүй, Засгийн газрын эрүүл мэндийн бодлогонд тусгаагүй байна.
- Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн хэлбэрүүд нь ялангуяа охид, эмэгтэйчүүдийн хүсэл зөвшөөрлөөс гадуур байж, аюулгүй бэлгийн харилцаанд орох сонголт, боломжгүй болгодог тул ДОХ/ХДХВ-ээр халдварлах зэрэгт амархан өртөх эмзэг байдлыг бий болгож байгааг анхааралдаа авах шаардлагатай.

#### **Шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлс:**

- Жендерийн тэгш бус байдал, эцгийн эрхт ёс, дэвшилтэт бус соёл, уламжлалаас үүдэлтэй хүйсээр ялгаварлан гадуурхах, дорд үзэх хандлага нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, жендерээс үүдэлтэй хүчирхийллийн үндсэн шалтгаан болж байна.

Мөн асуудлыг зөвшилцлийн арга замаар шийдвэрлэх мэдлэг, ур чадвар хангалтгүй байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үүсэх үндсэн шалтгааны нэгд зүй ёсоор орно. Тухайлбал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь

- Удаан хугацаагаар үргэлжлэх бие махбодийн гэмтэл аваагүй л бол шийтгэлийг байдаг л зүйл гэж үзэх хандлага нийтлэг.
- Түүнчлэн хүчирхийллийн дээрх төрлүүдэд ядуурал, архидалт, гадаад болон дотоод шилжих хөдөлгөөн, ажлын байрны хомсдол гм нийгэм, эдийн засаг, соёлын нөхцөл байдлууд маш эрчимтэй нөлөөлж байна. Иймээс дээрх асуудлуудын харилцан хамаарлыг тооцон үзсэн нэгдмэл, цогц олон талт стратеги, арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Бодлого, эрхзүйн орчин:**

- МУ-ын Засгийн газар нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциуд, Мянганы хөгжлийн зорилтууд гм олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, санаачилгуудыг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл зоригоо энэ төрлийн хөтөлбөр, бодлогуудыг хэрэгжүүлэхэд хангалттай төсөв хуваарилах замаар харуулах шаардлагатай байна. Жендерээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх явдал нь эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах ажлын гол ач холбогдол бүхий нэг хэсэг байх ёстой ч энэ чиглэлийн бодлого хөтөлбөрүүдэд хангалттай тусгагдахгүй байна.
- Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр чамлахааргүй бодлого, эрхзүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт нь туйлын хангалтгүй байна.
- Энэ нь бодлого, хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизм хангалтгүй, санхүүжилтийг улсын төсөвт суулгаж өгдөггүйтэй холбоотой. Төсөвт суусан ч хуваарилагдахдаа голдуу уламжлалт хөтөлбөрүүд, үйл ажиллагаанд /хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудын нийгмийн хамгаалал гм/ түлхүү хуваарилагддагаас бус жендерээс үүдэлтэй хүчирхийлэл гэх мэт шинээр гарч ирж байгаа асуудлуудад тэргүүлэх ач холбогдол өгөх нь ховор.

**Тогтолцоо, процедур:**

- Хүчирхийллийн дээрх төрлүүдээр тусгайлан ажиллахаар чиглэгдсэн тогтолцоо одоогоор бүрдээгүй. Байгууллага, институцүүдийн хоорондын уялдаа холбоо хангалтгүй, хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа нь салангид байна.
- Хүчирхийллийн дээрх төрлүүдийг илрүүлэх, хэрхэн шийдвэрлэх, яаж хариу үйлдэл үзүүлэх талаар тусгайлсан журам, стандартууд байдаггүй нь мэргэжилтнүүд өөрсдийн уламжлалт хандлага, үзэмжээр хандахад хүргэж байна.
- Иймээс эмнэлэг, хуулийн байгууллага, нийгмийн халамж, хамгааллын байгууллагуудад мөрдөх үйлчилгээний стандартуудыг баталгаажуулан мөрдөж, хүчирхийллийг даван туулах явцад учирч буй бэрхшээлийг судлан, саадыг арилгах шаардлагатай байна.

**Хамгаалал болон урьдчилан сэргийлэх байдал:**

- Хохирогчийг хамгаалах, эргэж хэвийн амьдралд нь оруулах, нөхөн сэргээх хүчирхийллийн дээрх төрлүүдийг үйлдсэн хүчирхийлэл үйлдэгчдийн алинд нь ч шийтгэл оноох, хариуцлага хүлээлгэх явдал хангалтгүй байна. Хүчирхийллийн

тохиолдлыг мэдээлэх, бүртгэх, хариу үйлдэл үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх, гэрч, хохирогчийг хамгаалах тусгайлсан бодлого, хууль, хөтөлбөрийг Засгийн газраас нэн даруй батлан хэрэгжүүлэх шаардлагатай.

- Энэ асуудлаар арга хэмжээ авахад эрүүл мэндийн мэргэжлийн ажилтнуудын туслалцаа чухал бөгөөд хүчирхийллийн тохиолдлыг илрүүлэх, шаардлагатай эмнэлгийн болон сэтгэл санааны туслалцаа үзүүлэхэд тэднийг тусгайлан сургах нь нэн чухал болоод байна.

Мөн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд боловсролын байгууллагуудын оролцоог дайчлах хэрэгтэй байна. Хүчирхийлэл үйлдэгчийг шийтгээд өнгөрөх бус олон нийтийн ойлголт, мэдлэг, хандлагыг өөрчлөх талаар урт хугацааны хөтөлбөрийг Засгийн газраас төлөвлөн хангалттай санхүүжилтээр хангах шаардлагатай гэж үзэж байна.

**Гэр бүлийн хүчирхийлэл**

- Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төвөөр үйлчлүүлсэн хохирогчдын дөнгөж 20 хувь нь цагдаа, хуулийн байгууллагад хандсан байна.
- 2 хохирогч тутмын 1 нь биедээ ямар нэгэн гэмтэл авсан боловч эмнэлгийн байгууллагад дөнгөж 5 хувь нь хандсан байна.
- ГБХ нь хувь хүний болон нийгмийн эрүүл мэндэд аюул учруулж байгаа ч эрүүл мэндийн асуудал болох талаас нь анхаарал хандуулах явдал сул байна.
- 2006 онд хамгаалах байраар нийт 277 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 10 гаруй хувиар өссөн байна. Тэдгээр эмэгтэйчүүдийн 98 нь хөхөрч няцарсан, зөөлөн эдийн гэмтэл авсан, 71 нь тархи хөдөлсөн, 10 нь ясны хугаралт, бэртэлттэй/хамрын яс, гарын бугалга, хөлийн шагай, эгэм хугарч мултарсан/, 14 нь толгой хагарч, уруул сэтэрсэн болон хөмсөг задарсаны улмаас оёдол тавиулсан байна.

2007 оны эхний 4 сард тус төвийн нийслэл дэх зөвлөгөө өгөх төвд 159 үйлчлүүлэгч үйлчлүүлж, сэтгэлзүйн болон хуулийн зөвлөгөө авснаа 53 хувь нь биедээ гэмтэлтэй ирсэн байна. Тус төвийн үйлчлүүлэгчдийн бүртгэлд хийсэн судалгаанаас үзэхэд 4 үйлчлүүлэгч тутмын 1 нь амиа хорлох сэдэл төрсөн абиа хорлох оролдлого хийсэн байна

**Гэр бүлийн хүчирхийлэл**

- Дээрх тоо баримтуудаас харахад ГБХ-ийн хохирогчдын дийлэнх хувь нь хөнгөн зэрэгт хамаарах гэмтэл авдаг нь гэр бүл дэх хүчирхийллийн үр дагаврыг ялимгүй гэдэг сэтгэгдлийг төрүүлдэг ч уг гэмтлийг удаа дараа давтан авч байдгаас

хохирогч сэтгэцийн эмгэг байдалд амархан ордог байна. Ясны цуурал, хамрын яс, шүдний хугарал зэрэг гэмтлүүд нь буцаад нөхөгдөх боломжгүй, хүний гоо сайхныг насан туршид нь алдагдуулдаг хэдий ч хөнгөн гэмтэлд тооцогдож байгаа нь анхаарвал зохих асуудал мөн.

- ГБХ-ийн улмаас хүнд, хүндэвтэр гэмтэл авагсдын тоо өмнөх жилүүдээс 2.5 дахин өссөн байна. ГБХ-ийн дахин давтагдах шинж нь түүний үр дагаврыг ноцтой болгох эрсдэлтэйг эрүүл мэндийн болон хууль хяналтын байгууллагууд дутуу тооцох хандлагатай байна.

### **Зөвлөмж:**

- ГБХ-ийн хохирогч, бусад гишүүдийн хэрэгцээ, сонирхол, насанд нь тохирсон цогц үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх нийгмийн ажлын үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг сайжруулан хөгжүүлэх
- Шүүх, цагдаа, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллага хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог тогтоосон удирдамж, журам, зааврыг хуулийн хэрэгжилтэнд голлох үүрэг гүйцэтгэх салбарын яамдуудаас баталж мөрдүүлэх
- Улсын болон орон нутгийн төсвөөс энэ чиглэлээр мэргэшсэн ТББ-дыг гэрээгээр санхүүжүүлэх журмаар хамгаалах байр, зөвлөгөө өгөх үйлчилгээг үндэсний хэмжээнд хүртээмжтэйгээр хүргэх
- Хохирогчийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үйлчлэх үйлчилгээг шуурхай, шат дамжлагагүй болгох зорилгоор Гэмтлийн эмнэлэг, аймаг, нийслэлийн томоохон клиникүүд дээр нэг цэгийн үйлчилгээг туршин нэвтрүүлэх

### **ХҮЧИН БОЛОН БЭЛГИЙН ХАЛДЛАГА**

- Хүчин, бэлгийн халдлага нь эмэгтэйчүүдийн амьдралын бүх үе шатанд тохиолдож, гэр бүлийн хосууд, ойр дотны хүмүүс, төрөл төрөгсөд, танил найз нөхдийн хооронд, танихгүй хүмүүсийн зүгээс зэрэг маш өргөн харилцааны хүрээнд үйлдэгдэж байна.
- Энэ нь эмэгтэй хүнийг хүйсээр ялгаварлан гадуурхаж, дорд үздэг нийгмийн хандлагаас үүдэлтэй үйлдэгддэг эрх мэдлийн гэмт хэрэг, хувь хүний аюулгүй, халдашгүй чөлөөт байдлын эсрэг үйлдэл юм. Хүчин нь хүний бие махбодын гагцхүү "бэлгийн" эсрэг дайралт биш үнэн хэрэгтээ хүний бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэндийн бүрэн бүтэн байдал, өөртөө итгэх итгэл, нэр төр, өөрийнхөө сэтгэл санаа, бие махбодыг өөрийн хүслээр захирахын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг юм.

- Эрүүгийн хуулинд зааснаар хүчин болон бэлгийн халдлага нь хүний эрх, эрх чөлөөний эсрэг бус нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт багтдаг. Хувийн халдашгүй байдлын эсрэг эрх мэдлээ мэдрэх гэж үйлдсэн гэмт хэрэг гэж үзэхээс илүүтэй дур хүсэлтэй холбон үздэг.

### **ХҮЧИН БОЛОН БЭЛГИЙН ХАЛДЛАГА**

- Хүчин болон бэлгийн халдлага нь охид, эмэгтэйчүүдэд хэзээ, хаана хэнтэй, ямар байдлаар бэлгийн харьцаанд орох гэдгээ шийдэх, хяналт тавих боломжгүй болгосноороо эмэгтэйчүүдийн БЗХӨ/ ДОХ/ХДХВ-н халдвар авах эрсдлийг маш ихээр нэмэгдүүлэх аюултай байна.

### **Зөвлөмж:**

- Хүчингийн гэмт хэргийг хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэнд халдсан эрх мэдлийн гэмт хэрэг гэж томъёолох, уг гэмт хэргийн тодорхойлолтыг өргөтгөж, ураг төрлийн, болзооны, гэрлэгсэд хоорондын хүчингийн төрлийг оруулах, мөн “итгэл эвдэх”, “хууран мэхлэх” арга замаар үйлдэгдэж болохыг тодорхойлох
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдийн биеийн болон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчинг тодорхой болгож, эргэн хэвийн амьдралд нь оруулж нөхөн сэргээх зэрэг үйлчилгээг төв, орон нутагт бий болгон төрөөс дэмжих
- Албан, албан бус боловсролын системээр дамжуулан бэлгийн боловсролыг стандарчлагдсан хөтөлбөр, агуулгаар олгох, мэргэжлийн бэлтгэгдсэн багшаар хангах
- Хүчингийн гэмт хэргээр дагнан мэргэшсэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчдийг бэлтгэх, цагдаа, улсын мөрдөн байцаах газарт тусгай хэлтэс тасаг ажиллах боломжийг судлан хэрэгжүүлэх
- Бэлгийн хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх мэдлэг, ур чадварыг эмнэлгийн ажилтнуудад олгох хөтөлбөрийг ЭМЯ-аас тусгайлан боловсруулж хэрэгжүүлэх

### **ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРЭГ**

- Хүн худалдах гэмт хэрэг нь хүний эрхийг зөрчсөн ноцтой гэмт хэрэг юм. Хүн худалдах нь дэлхий дээрх зэвсэг, хар тамхины дараа орохуйц хамгийн унац ихтэй хууль бус бизнес бөгөөд зохион байгуулалттай гэмт хэргийн ашиг орлогын гол эх үүсвэр болдог.

- Хүн худалдах гэмт хэрэг МУ-д шинээр бий болж байгаа жендерт суурилсан хүчирхийллийн хэлбэр ч асар богино хугацаанд нийгмийн эмгэг үзэгдэл болж цар хүрээ нь хурдацтай нэмэгдэж байна
- МУ-д охид, эмэгтэйчүүдийг гадаад, дотоодод хүчээр бэлгийн мөлжлөгт ашиглах, гадаадын иргэдтэй гэрлүүлэх хэлбэр илүү зонхилж байна. ХХГХ-ийн далд шинж чанараас үүдэн энэ тухай тоо мэдээг нарийн тогтооход төвөгтэй.
- ХХГХ-ийн хохирогч эмэгтэйчүүд бусдын эрхшээлд орж, ямар төрлийн ажил хийх, ямар нөхцөлд хөдөлмөрлөх зэрэгтээ хяналт тавих боломжгүй учраас эрүүл мэндийн эрсдэлд ордог. Тэдний хувьд сонголт хийх, бэлгэвч хэрэглэх эрх мэдэлгүй тул ДОХ/ХДХВ-ийн өндөр эрсдэлд байдаг.

### **АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТЛАЛ**

- Бэлгийн дарамтлал нь эрх мэдлийн тэгш бус байдлын илрэл. Бэлгийн дарамтлал нь бэлгийн сэдэлттэйгээр дооглон тохуурхахаас эхлээд хүсээгүй, хүлээн авашгүйгээр шахалт дарамт үзүүлж, бэлгийн хүсээгүй харилцаанд оруулах хүртэл үйлдэгддэг гэмт хэрэг юм.
- Бэлгийн дарамт нь хувь хүний халдашгүй байдалд аюул занал учруулж, ажлын байран дахь эрх тэгш байдлыг үгүй болгодог. Ажлын байр гэдэгт хөдөлмөр эрхэлдэг орон зайн тухай биш, бэлгийн хүчирхийллийг нөхцөлдүүлж байгаа орчин, хүмүүсийн харилцааны байдлыг голлон авч үздэг.
- Ажлын байран дахь бэлгийн дарамтлал нь үгээр, үйл хөдлөлөөр, бие махбодийн янз бүрийн хэлэмжүүдээр илэрдэг. Бэлгийн сэдэлттэй үйлдэл, үг хэллэг, хэлэмжүүд нь дангаараа бэлгийн дарамтлал бус харин ийм зан авир нь хүлээж авшгүй, хүлээж авсан ч хортой үр дагавартай байх нь гол шинж гэж үзэж байна. Тухайлбал: хүлээж аваагүйн улмаас ажилгүй болох, албан тушаал дэвшихгүй байх, эсхүл үр дагавраас нь зайлсхийж хүлээж авсан байх гм.

### **АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТЛАЛ**

- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хэн боловч ажил үүргээ гүйцэтгэх явцдаа бэлгийн харилцаатай холбоотой аливаа дарамт, доромжлолгүй нөхцөлд, айдас түгшүүрээс ангид ажиллах ёстой ч сүүлийн жилүүдэд ажлын байран дахь бэлгийн дарамтлалд эмэгтэйчүүд илүүтэй өртөж байгаа талаарх баримтыг хүний эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-ууд хөндөн ярих болоод байна.
- АББД нь үйлдвэр, аж ахуйн газар буюу ажлын байранд, олон нийтийн үйлчилгээний газар, сургууль, боловсролын байгууллагад илүү гардаг байна.

Судалгаанд оролцсон 533 хүний 280 нь буюу 53% нь АББД-д өртсөн байна. АББД-д эмэгтэйчүүд илүүтэй өртөж байгаагаас 20-35 насныхан зонхилж байна.


**Зөвлөмж:**

- Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг төлөвлөн ЗГ-тай байгуулах “Нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр”-ээр баталгаажуулан хэрэгжүүлэх
- АББД-ын улмаас хохирсон хохирогчийг хамгаалах, нийгэмшүүлэх нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлэх

**МОНГОЛ ДАХЬ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ЦАР ХҮРЭЭ, ҮР ДАГАВАР**

ХЭҮТ-ийн Хүүхэд хамгааллын нэгжийн зохицуулагч Л.Бадамцэцэг

Монгол улсын нийт хүн амын 46,6%-ийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлдэг. 2 хүүхдийн нэг нь хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртдөг байна. Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн эсрэг дарамт хүчирхийлэл түгээмэл бөгөөд хүүхэд цэцэрлэг сургууль, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллага болон гэр бүлийн орчинд илүү өртөж байна.



### **Монгол дахь хүүхдийн эсрэг хүчирхийллийн цар хүрээ, үр дагавар**

- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй дарамт хүчирхийлэл, үл хайхрах явдлыг насны хувьд авч үзвэл бага насныхан бие махбодын болон үл хайхрах явдлын, өсвөр насныхан сэтгэл санааны; хүйсийн хувьд хөвгүүд бие махбодын, охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт илүү өртөмтгий байна.
- Хүчингийн нийт гэмт хэргийн 26.6%-ийг ураг төрлийн хүчин эзэлж байгаа бөгөөд хохирогчийн 40 орчим хувь нь бага насны/ 5-14 нас/ охид байна.

### **Монгол дахь хүүхдийн эсрэг хүчирхийллийн цар хүрээ, үр дагавар**

- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэл нь тэдний эрүүл мэнд, амь насанд аюул занал учруулж байна. 2003-2005 онд гэр бүл, сургууль, гудамж талбайд хэн нэгэнд зодуулснаас бэртэл гэмтэл авсан 5129 хүүхэд Гэмтлийн эмнэлэгт ирж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Хүүхэд гэмт хэргийн улмаас амь насаа алдах, бэртэж гэмтэх явдал жил бүр өссөөр ирснийг судалгаа харуулж байна.
- Цагдаагийн байгууллагаас албан ёсоор гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн талаар дараах мэдээллийг гаргасан байна.

2000	2001	2002	2003	2004	
112	95	89	120	134	<b>1527</b>

## **Эмнэлэг дээр суурилсан нэг цэгийн үйлчилгээ**

### **Төрийн бус байгууллагын оролцоо**

ХЭҮТ-ийн Хүүхэд хамгааллын нэгжийн зохицуулагч Л.Бадамцэцэг

### **Эрх зүйн үндэслэл: ГБХТТХ-ийн 12-р зүйл. Итгэмжилсэн төлөөлөгч**

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.
- **12.2.1.**Хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн болон ТББ, бусад этгээдтэй харилцах
- Хүчирхийллийн холбоотой мэдээлэл олж авах, судалгаа явуулах
- ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны саналаа эрх бүхий байгууллагад оруулах

### **ГБХТҮХ-ТББ – ын оролцоо**

- Хүчирхийллийн хохирогчдод үнэ төлбөргүй нийгэм сэтгэл зүй, хууль зүйн туслалцаа үзүүлэх
- Хуулиар үүрэг хүлээсэн шүүнч, прокурор, цагдаа, өмгөөлөгч, сэтгэл зүйч, эрүүл мэнд, боловсролын байгууллагын ажилтан, салбарын бодлого боловсруулагч мэргэжилтнүүдэд цогц сургалтыг явуулах
- Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх
- Хууль, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, үр дүнг үнэлэн, сайжруулах нэгдсэн стандарт боловсруулж мөрдөх
- Хөрөнгө нөөц бүрдүүлэх, стратеги боловсруулан хэрэгжүүлэх

### **Нэг цэгийн үйлчилгээний төвтэй хамтран ажиллах ТББ–ын оролцоо**

**Кейсийг бүртгэхээс эхлэн хаах хүртэлх бүхий л үйл явцад оролцоно.**

#### **Анхан шатны урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

- Үйлчлүүлэгчийг хэрэгцээт мэдээллээр хангах
- Гэр бүлийн болон бусад орчинд нөхцөл байдлын болон хэрэгцээний үнэлгээг хийх, кейс төлөвлөлт боловсруулах
- Эмнэлгийн тусламж дэмжлэг шаардлагатай үйлчлүүлэгчийг холбон зуучлах
- Олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
- Нөлөөллийн үйл ажиллагаа
- Дэмжих бүлэг хичээллүүлэх

#### **Хоёр дах шатны урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

- Сэтгэл зүйн болон хуулийн зөвлөгөө
- Дэмжих бүлэг
- Кейс менежемент хийх
- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, түр хугацаагаар хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх

#### **Гурав дах шатны урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

- Хуулиар асуудлыг шийдвэрлэхэд хэрэгцээт мэдээллээр хангах
- Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох
- Гэр бүлийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээ үзүүлэхэд холбон зуучлах
- Хүчирхийллийг даван туулахад туслах үйл ажиллагаа
- Нийгмийн болон эрх зүйн орчныг боловсронгуй болгоход нөлөөлөх нөлөөллийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэхэд бусад салбарынхантай хамтран ажиллах

### **ХЭҮТ-ийн салбар ба хамгаалах байрууд**

- Дорнод, Баянхонгор
- Өвөрхангай, Завхан
- Баян - Өлгий, Ховд
- Налайх, Багануур
- Хэнтий
- Төв, Дархан
- Эрдэнэт, Сэлэнгэ
- Дундговь, Өмнөговь

### **Хамгаалах байрууд**

- Улаанбаатар 2
- Дундговь
- Сэлэнгэ
- Төв
- Ховд
- Өвөрхангай

## **Зөвлөмж**

Сургалтыг зохион байгуулсаны дараа холбогдох байгууллагуудаас хүрэлцэн ирсэн оролцогчыг бүлэг болгон хуваан ажиллуулав. Бүлгүүдээс гарсан саналыг нэгтгэсний дагуу дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Гэр бүл, жендэрээс үүдэдтэй хүчирхийлэл ба хүүхдийн хүчирхийлэлд өртөгсөдөд зориулсан нэг цэгийн үйлчилгээг эхний ээлжинд Гэмтэл Согогийг Судлалын Үндэсний Төвдээр байгуулах боломжтой байна.
- Хүчирхийлэлд өртсөн хүмүүс эхний ээлжинд эмнэлгийн анхан шатны тусламж авхаар ГССҮТ-руу очих ба тэнд 24 цагийн цагдаагийн ажилтан ажилладаг, нийгмийн ажилтан ажиллах нөхцлийг бүрдүүлбэл нэг цэгийн үйлчилгээ нь ажиллахад бүрэн боломжтой байна. Иймээс ГССҮТ нь нэг цэгийн үйлчилгээндээр ажиллаж, бусад байгууллагатай холбох зэрэг асуудлаа хариуцсан нийгмийн ажилтантай болох
- Хүчирхийлэлд өртөгсөдөд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, анхан шатны маягтыг боловсронгуй болгох, холбогдох протокол, гарын авлагыг боловсруулж мөрдүүлэх
- Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх цэгт болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж, санхүүжилт хийх
- Бүлгийн ажлаас гарсан саналын дагуу шүүх эмнэлэг, аймаг, сум, хорооны түвшинд олон нийтэд суурилсан нэг цэгийн үйлчилгээг ажиллуулах, өргөжүүлэх
- Эмч, эмнэлгийн ажилтан, цагдаагийн ажилтан, шийдвэр гаргагч болон бусад холбогдох байгууллагын мэргэжилтэнд хүчирхийллийн асуудлаар төрөл бүрийн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан сургалтыг зохион байгуулах

**“Хүчирхийлэлд өртсөн хүмүүст үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ” дотоодын сургалтын хөтөлбөр**

<b>Хэзээ: 2007 он 12 сарын 10-11 өдөр</b>		<b>Хаана: ГССҮТ-ын</b>
<b>хурлын заал</b>		
<b>Хугацаа</b>	<b>Үйл ажиллагаа</b>	<b>Хариуцах эзэн</b>
<b>2007 оны 12 дүгээр сар 10</b>		
09:00 - 09:10	Бүртгэл	
09:10 - 09:20	Нээлт, сургалтын танилцуулга	Ц.Бүжин, ЭМЯ С. Отгонгэрэл, ГССҮТ
09:20 - 09:30	Оролцогсод өөрсдийгөө танилцуулах	Оролцогсод
09:30 – 09:45	ЭМЯ-аас жендер сууриласан болон хүүхдийн хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр баримталж буй бодлого	Б. Цэцэгсайхан ЭМЯ-ны мэргэжилтэн
09:45 – 10:45	ДЭМБ-ын мэдээлэл, хүчирхийлэлээс сэргийлэх чиглэл явуулж буй үйл ажиллагаа	ДЭМБайгууллагын бүсийн зөвлөх
10:45-11:00	Цайны завсарлага	
11:00– 11:30	Нэг цэгийн үйлчилгээний агуулга /үзэл баримтлал/, нэг цэгийн үйлчилгээний менежмент	С. Баасанбат, ТББ
11:30-12:00	Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал	С. Баасанбат, ТББ
12:00-12:30	Клиник, нэг цэгийн үйлчилгээний шалгуур үзүүлэлтүүд	Р.Шагдарсүрэн, ГССҮТ
12:30-13:00	Цагдаагийн оролцоо	Б. Батзориг, ЦА
13:00 – 14:00	Үдийн завсарлага	
14:00- 14:30	Гэрчийн мэдүүлэг, нотлох баримт бүрдүүлэх менежмент /шүүх эмнэлэгийн магадлагаа/	Б. Батзориг, Цагдаагийн Академи
14:30-15:00	Жендер сууриласан хүчирхийлэлийн судалгаа	Л. Бадамцэцэг, ХЭҮТ
15:00-15:30	Гэрчийн мэдүүлэг /шүүхийн магадлагаа/	Б. Батзориг, Цагдаагийн Академи
15:30-16:00	Гэрчийн мэдүүлэг, шинжээчдийн дүгнэлт гаргах менежмент	Б. Батзориг, Цагдаагийн Академи
16:00-16:30	Цайны завсарлага	
16:30-17:00	Дүгнэлт	Р.Энхсайхан С. Баасанбат, Ш. Нансалмаа
<b>2007 оны 12 дүгээр сар 11</b>		
09:00 - 09:15	Бүртгэл	
09:15 - 09:45	Шүүх эмнэлэгийн оролцоо	Н.Мөрөн , Шүүх эмнэлэг
09:45-10:15	Криминалистикийн шинжилгээ, гэмтлийн зэрэг тогтоох протокол	Н.Мөрөн , Шүүх эмнэлэг
10:15-10:45	ТББ-ын оролцоо	Л. Бадамцэцэг, ХЭҮТ
10:45-11:00	Цайны завсарлага	
11:00-11:30	Хохирогчийн сэтгэл зүйн хохирол, нөхөн сэргээх зөвлөгөө засал	С. Баасанбат, ТББ
11:30-12:00	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хамтарсан багийн оролцоо	Л. Бадамцэцэг, ХЭҮТ
12:00-13:00	Хүлээн авах эхний шатны үйлчилгээний чадавхи	С. Баасанбат, ТББ
13:00-14:00	Үдийн завсарлага	

14.00-15.30	Практик ажиллагаа	Багш нар
15.30-16.00	Хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хохирогчтой харилцах цагдаагийн албан хаагчын гарын авлага	Б. Батзориг, Цагдаагийн Академи
16:00–17.00	Дүгнэлт, хаалт	ГССҮТ С.Отгонгэрэл, Д.Мөнхбат, Р.Энхсайхан, Багш нар

Хавсралт 12

### Сургалтанд оролцсон хүмүүсийн нэрс

#### Нэг. ГССҮТөв

1. Д.Мөнхбат	ЭЭ орлогч захирал	23. С.Сүхбат	их эмч
2. Р.Энхсайхан	ЯТЭ орлогч захирал	24. Т.Дэлгэрхүү	их эмч
3. Р.Шагдарсүрэн	ШЭСЭ дэд захирал	25. Х.Туяа	их эмч
4. Ш.Нансалмаа	НЭМ-ийн эм	26. М.Тэмүүжин	их эмч
5. Б.Янжинлхам	их эмч	27. Э.Галбадрах	их эмч
6. С.Цэрмаа	их эмч	28. Б.Батбаяр	их эмч
7. Т.Төртулга	их эмч	29. А.Амгаланбаатар	их эмч
8. Т.Мөнхсайхан	их эмч	30. Д.Баасанжав	их эмч
9. Д.Оюунжаргал	их эмч	31. Л.Батхуяг	их эмч
10. Д.Даваажаргал	их эмч	32. Т.Бат-Эрдэнэ	их эмч
11. А.Эрдэнэбилэг	их эмч	33. Л.Нанжид	их эмч
12. О.Батсүх	их эмч	34. Ш.Цэцэгсанаа	их эмч
13. Б.Батаа	их эмч	35. Г.Батмөнх	их эмч
14. Б.Баярсайхан	их эмч	36. Ц.Цэнд-Очир	их эмч
15. Д.Бархүү	их эмч	37. Г.Бадамгарав	их эмч
16. Д.Ариунзаяа	их эмч	38. Р.Баяртулга	их эмч
17. Б.Баатаржав	их эмч	39. Н.Оюунчимэг	их эмч
18. Ч.Мөнхбат	их эмч	40. И.Гантулга	их эмч
19. С.Татаар	их эмч	41. Б.Цэцэнхүү	бага эмч
20. Г.Ариунаа	их эмч	42. С.Гэрлээ	бага эмч
21. Д.Мөнхбаяр	их эмч	43. Б.Эрдэнэбат	их эмч
22. Д.Гантулга	их эмч	44. П.Баярсайхан	их эмч

**Хоёр.** Шүүх эмнэлгээс

- |                  |                          |
|------------------|--------------------------|
| 1. Н.Мөрөн       | ШШҮТ-ийн ШЭХ-ийн менежер |
| 2. С.Ганболд     | ШШҮТ-ийн ШЭХ-ийн эмч     |
| 3. Н.Долгорсүрэн | ШШҮТ-ийн ШЭХ-ийн эмч     |
| 4. Р.Аюушбаатар  | ШШҮТ-ийн ШЭХ-ийн эмч     |
| 5. Д.Энхбаяр     | ШШҮТ-ийн ШЭХ-ийн эмч     |

**Гурав. НЦЕГазраас**

- |                  |                                      |
|------------------|--------------------------------------|
| 1. М.Наранцолмон | ШУТ-ийн чиглэлийн ахлах ажилтан, д/х |
| 2. Б.Шаравжамц   | ШУТ-ийн ахлах хэрэг бүртгэгч, хошууч |
| 3. Н.Сүхбаатар   | ШУТ-ийн ахлах хэрэг бүртгэгч, д/х    |
| 4. Д.Энхтөр      | ШУТ-ийн ахлах хэрэг бүртгэгч, д/х    |
| 5. Б.Бавуу       | ШУТ-ийн ахлах хэрэг бүртгэгч, хошууч |

**Дөрөв. Нийслэлийн дүүргүүдээс**

- |                  |  |
|------------------|--|
| 1. Л.Гандираа    | Багахангай дүүргийн ЭМН-ийн гэмтлийн эмч |
| 2. Б.Батжаргал   | Налайх дүүргийн ЭМН-ийн гэмтлийн эмч     |
| 3. У.Уртнасан    | БЗД-ийн ЭМН-ийн гэмтлийн эмч             |
| 4. С.Алтанзул    | ЧД-ийн ЭМН-ийн гэмтлийн эмч              |
| 5. Ж.Эрдэнэчимэг | ХУД-ийн ЭМН-ийн гэмтлийн эмч             |
| 6. М.Энхтуяа     | СБД-ийн ЭМН-ийн гэмтлийн эмч             |
| 7. Л.Наранбаатар | БГД-ийн ЭМН-ийн гэмтлийн эмч             |
| 8. Т.Цагаандорж  | Багануур дүүргийн ЭМН-ийн гэмтлийн эмч   |

**Тав. Аймгуудаас**

- |                   |  |
|-------------------|--|
| 1. А.Баттулга     | Архангай аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч   |
| 2. Д.Ганзориг     | Баянхонгор аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч |
| 3. З.Хурметхан    | Баян-Өлгий аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч |
| 4. М.Олзмөнх      | Булган аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч     |
| 5. О.Мэндсайхан   | Говь-Алтай аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч |
| 6. Р.Энхбаатар,   | Дархан-Уул аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч |
| 7. У.Эрдэнэтулга  | Дархан-Уул аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч |
| 8. Г.Хүрэлбаатар  | Дорнод аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч     |
| 9. Х.Эрдэнэбулган | Дорноговь аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч  |

10. Э.Ариунхүү	Дундговь аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
11. Ч.Дэмчигсүрэн	Завхан аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
12. Т.Батсайхан	Өвөрхангай аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
13. Ж.Зоригт	Өмнөговь аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
14. Р.Цолмон	Сэлэнгэ аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
15. Б.Мангалжав	Сүхбаатар аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
16. А.Батхүү	Төв аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
17. Н.Даржаа	Ховд аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
18. Д.Эрдэнэбаатар	Хөвсгөл аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч
19. Ч.Энхжав	Хэнтий аймг ийн НЭ-ийн гэмтлийн эмч
20. Ж.Батсүх	Увс аймгийн НЭ-ийн гэмтлийн эмч

